НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

# НЭГ ХОТ СТАНДАРТ

**2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот**
**2021 он**

ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

БАТАЛСАН АЛБАН ТУШААЛТНЫ
ГАРЫН ҮСГИЙН ТАЙЛАЛ

ТАНИЛЦСАН:
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . /С.ТӨМӨРДУЛАМ/

8314551 ☩ 1119284894

ТАНИЛЦСАН:
ОРЛОГЧ ДАРГА . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . /О.ОДЖАРГАЛ/

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА . . . . . . . . . . . . . . /Э.ДАВААХАТАН/

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН: . . . . . . . . . . . . . . . . . /С.БОЛДОО/

## ГАРЧИГ


**ОРШИЛ** .......... 3

**ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТ /2019-2021/** .......... 4

**НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН** .......... 5

1.1 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ: .......... 5

1.2. НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭ .......... 6

**ХОЁР. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН** .......... 13

2.1 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭР .......... 13

2.2. НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ, ШИЙДВЭР .......... 14

2.3. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ .......... 15

2.3.1. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ .......... 15

2.3.2 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР .......... 23

2.4. НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССООС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР .......... 25

**ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ** .......... 28

3.1. ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУДАЛГАА ХИЙХ .......... 28

3.2. ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ .......... 34

3.3. ХОТЫН СТАНДАРТЫН УДИРДАМЖ АРГА ЗҮЙН БАРИМТ БИЧИГ .......... 34

3.4. ХОТЫН СТАНДАРТЫН ЗӨВЛӨГӨӨН, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА .......... 36

3.5. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ .......... 36

**ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ** .......... 39

4.1. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .......... 39

4.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДАЛ .......... 41

4.3. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ .......... 43

**ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ** .......... 43

5.1. НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ .......... 43

5.2. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА .......... 44

5.3. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН .......... 45

5.4. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАН МЭДЭЭ .......... 49

5.5. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ .......... 51

5.6. БУСАД НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙ АЖИЛ .......... 53

5.7. НИЙТ АЛБАН ХААГЧДЫН ОРОЛЦСОН АЖЛУУД: .......... 58

**ДҮГНЭЛТ** .......... 61

# ОРШИЛ

Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангахад төр, хувийн хэшлийн байгууллагуудын оролцоо, идэвхи зүтгэл, харилцан уялдаа холбоо нэн чухал болсон өнөө цагт бүхий л үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, шаардлагуудыг мөрдүүлснээр хотын хөгжилд оролцогч талуудын дунд чанарт суурилсан харилцан итгэлцэл тогтож нийслэл хотын хөгжлийн бодлогын зорилтууд амжилттай хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ.

Манай байгууллага нийслэлийн нутгийн захиргааны удирдах байгууллагууд, хамтран ажилладаг агентлаг, харьяа газрууд болон аж ахуй нэгж, иргэдийн хууль ёсны итгэл, хүлээлт, сэтгэл ханамжийг ямагт өндөр байлгахын тулд цар тахлын халдвар дэгдэж удаа дараагийн хөл хорио тавигдсан хүнд бэрх цагт хамт олноороо санаа, сэтгэл нэгдэн нягтарч хотын стандартын тогтолцоог бий болгохын төлөө хэрэгжүүлсэн дараах хэд хэдэн арга хэмжээг онцолж болно. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж дотоод дүрэм журам, удирдлагын үйл ажиллагааг түүнд нийцүүлж өдөр тутмын үйл ажиллагаандаа дотоод аудитыг тогтмолжуулж тасралтгүй сайжруулах тогтолцоо үйлчилж эхэлсэн.
- Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг 22 бүлэг сэдвийн хүрээнд 97 төрлөөр боловсруулж нийслэлийн хэмжээнд мөрдүүлэхээр НЗД-ын 2021 оны А/456 дугаар захирамж батлуулан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд нийслэлийн хэмжээнд улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын
- Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажилласны үр дүнд “хотын стандарт”-ын талаар эрх зүйн үндсийг бий болгож 2022 оны эхнээс мөрдүүлэх бэлтгэл хангуулан ажиллаж байна.
- Амьдрах орчны аюулгүй байдлын судалгааг сургууль, цэцэрлэгийн гадна орчин, хүүхдийн тоглоомын талбай, Сууц өмчлөгчдийн холбооны гадна орчны судалгаа гэх мэт нийт 11 чиглэлээр зохион байгуулж үр дүнг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж орчны аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэв.
- Нийслэлийн хэмжээнд баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг төрийн үйлчилгээний цахим систем болох e-mongolia.mn цахим системээр дамжуулан судалж ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж тухайн барилгын мэдээллийг мөн цахим системээр дамжуулан бүртгэж мэдээллийн санг бүрдүүлж эхэлсэн. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-д нийцүүлэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс, Барилга байгууламжийн гадна тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/862 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Дээрх өөрчлөлтүүд нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан дүгнэлт баталгаажуулах үйл ажиллагаанд зарцуулах хугацаа, ажлын зохион байгуулалт сайжирсан. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 25 зорилтын 69 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж 2021 оны эцсээр 96 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан бөгөөд 2021

оны үйл ажиллагааны үр дүнд байгууллагын чанарын бодлого, зорилтоо бодитоор хэрэгжихэд зайлшгүй шаардлагатай үйл явц хэрэгжсэнээрээ онцлогтой байна.

## ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТ /2019-2021/

| № | Чиг үүрэг | Ажлын үзүүлэлт | Хэмжих нэгж | 2019 | 2020 | 2021 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд | | | | | | |
| 1 | Стандарт, норм дүрэм судлах | MNS үндэсний стандарт | тоо | 190 | 443 | 280 | **913** |
| 2 | | БНбД норм, дүрэм | | 15 | 180 | 314 | **509** |
| 3 | | Олон улсын баримт бичиг, стандарт ISO, EN, Гост | | 6 | 80 | 175 | **261** |
| 4 | Стандарт, норм, дүрмийн төсөлд санал өгөх | MNS үндэсний стандарт | | 0 | 10 | 4 | **14** |
| 5 | | БНбД норм, дүрэм | | 2 | 8 | 29 | **39** |
| 6 | Хотын стандартын удирдамж /Боловсруулсан/ | Суурь судалгаа | сэдвийн тоо | 3 | 36 | 80 | **119** |
| 7 | | Хотын стандартын удирдамж боловсруулалт | | 3 | 14 | 80 | **97** |
| 8 | Станартын хэрэгжилтийн арга зүйгээр хангах | Нийслэлд хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажилд стандарт хэрэгжүүлэх талаар зөвлөн туслах | ажлын тоо | - | 62 | 129 | **191** |
| 9 | | Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгээр хангах | баримт бичгийн тоо | - | 6200 | 9843 | **16043** |
| 10 | Хотын стандартын талаарх сургалт | Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичиг /нийслэлийн байгууллагууд/ | Сургалтанд хамрагдсан хүний тоо | - | 535 | 1137 | **1672** |
| 11 | | Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартын сургалт /удирдах албан хаагчдад зориулсан/ | | - | - | 131 | **131** |
| 12 | | "Хотын стандарт-Хотын соёл" арга хэмжээний хүрээнд оюутан, залуусыг сургалт зохион байгуулах | | - | - | 1253 | **1253** |
| 13 | Орчны аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ | Орчны аюулгүй байдлын судалгаа | Судалгааны төрөл, тоо | 21 | 6 | 11 | **38** |
| 14 | | Нийтийн эзэмшлийн орц, гарц гаргах | | - | 92 | 82 | **174** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | | Барилгын гадна орчны аюулгүй байдлыг хангуулах | Зөрчил арилгасан | - | 379 | 307 | **686** |
| 16 | Мэдээллийн сан бүрдүүлэх | Ашиглалтад орж буй барилгыг мэдээллийг санд бүртгэх | Барилга байгууламж тоо | - | 421 | 879 | **1300** |
| 17 | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах | Барилга | | - | 118 | 245 | **363** |
| 18 | | Гадна цахилгаан хангамж | | - | 206 | 420 | **626** |
| 19 | | Гадна гэрэлтүүлэг | | - | 14 | 17 | **31** |
| 20 | | Барилгын их засвар, шинэчлэлт | | - | 22 | 10 | **32** |
| 21 | | Гадна тохижилт | | - | 64 | 48 | **112** |
| 22 | | Инженерийн шугам сүлжээ | | - | 60 | 82 | **142** |
| 23 | Нийтлэг чиг үүргийн хүрээнд | | | | | | |
| 24 | Дээд газрын шийдвэрээр бүрэлдэхүүнд нь орж ажилласан ажлын хэсгийн мэдээлэл | МУЗГ болон түүний харьяа яам, агентлагийн шийдвэр | Шийдвэрийн тоо | 2 | 1 | 4 | **7** |
| 25 | | НИТХ-ын даргын шийдвэр | | - | - | 3 | **3** |
| 26 | | НЗД-ын захирамжаар орж ажилласан ажлын хэсэг | | 19 | 6 | 25 | **50** |
| 27 | | УБ хотын Ерөнхий менежерийн тушаал | | - | 2 | 6 | **8** |
| 28 | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, санал өгөх | Хуулийн төсөл | Санал хүргүүлсэн тоо | 4 | 3 | 11 | **18** |
| 29 | | Журмын төсөл /МУЗГ, НИТХ-ын тогтоол/ | | 3 | 3 | 3 | **9** |
| 30 | | Төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний төсал | | 16 | 20 | 6 | **42** |
| 31 | Иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт шийдвэрлэлт | | тоо | 8 | 213 | 198 | **419** |
| 32 | Нийслэлийн онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх | Биелүүлсэн үүрэг даалгаврын тоо /Сайжруулсан түлш, Ковид-19 халдвартай тэмцэх/ | өгөгдсөн үүрэг даалгаврын тоо | 1 | 2 | 5 | **8** |
| 33 | | Оролцсон албан хаагчдын тоо /давхардсан тоогоор/ | албан хаагчдын тоо | 21 | 47 | 68 | **136** |
| 34 | | Зарцуулсан өдөр | тоо | 60 | 218 | 88 | **366** |

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### 1.1. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Монгол улсын болон нийслэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд тус газрын дүрмээр хүлээсэн чиг үүрэгтэй холбоотой нийт 4 зорилт тусгагдсанаас МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт-1, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 3 арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүллээ.

**Арга хэмжээ 2.3.9: Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх хүрээнд дараах боловсролын байгууллагын барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулав.**

- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн захиалгаар Баянгол дүүргийн 16 дугаар хороонд баригдсан Барилгын политехник коллежийн дадлагын байр,
- Налайх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт Налайх-Мэргэжил үйлдвэрлэлийн сургалтын үндэсний төвийн байр,
- Хятадын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Боловсрол Шинжлэх ухааны яамны захиалгаар Хан-Уул дүүргийн 2 дугаар хороонд баригдсан 828 хүүхдийн суудалтай, 75 дугаар сургуулийн барилга,
- Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Дүүргийн Засаг даргын тамгын газрын захиалгаар баригдсан 100 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга

Зураг 1. 75 дугаар сургууль, 100 хүүхдийн цэцэрлэг, барилгын политехник коллеж



## 1.2. НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд тус газрын үйл ажиллагаатай холбоотой хийж хэрэгжүүлэх 4 зорилтын 6 арга хэмжээг газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, баталгаажуулан ажиллав. Энэ ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

**Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2016, MNS ISO 18091 стандартыг**

**үйл ажиллагаанд нэвтрүүлэх. /Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.3.1 дэх заалт/**

Газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/100, А/101 тушаалаар байгууллагын үйл ажиллагаанд “Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015” олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн.

Уг ажлын хүрээнд байгууллагын Чанарын багийг томилж, 4 дэд багаар, 8 бүлгийн 46 ажлыг төлөвлөн хийж гүйцэтгэв. “Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015” олон улсын стандартыг нэвтрүүлэх 6 төрлийн сургалт хийгдэж давтагдсан тоогоор 88 албан хаагч сургалтад хамрагдсан. Эдгээр сургалтад хамрагдсанаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад дээрх стандартыг нэвтрүүлэх үйл ажиллагааг удирдамж, арга зүйгээр хангах албан хаагчдыг бэлтгэсэн.

Зураг 2. Байгууллагын чанарын менежментийн тогтолцооны зураглал




Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх явцад байгууллагын сонирхогч талууд, тэдгээрийн хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлж **Төлөвлө, Гүйцэтгэ, Шалга, Сайжруул** гэсэн чанарын тогтолцооны үндсэн үе шат бүрд хийгдэх үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж нийт албан хаагчдыг жигд мэдээллээр хангаж ажиллав.

Зураг 3. Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартын Тэргүүлэх зэргийн аудитор, дотоод аудиторын гэрчилгээг гардуулав.



Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор 2 шатны баталгаажуулалтын аудит хийгдэж 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдөр баталгаажуулалтын гэрчилгээг гардан авав.

Зураг 4. Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартын баталгаажуулалтын гэрчилгээг хүлээн авлаа.



Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэнээр дараах эерэг өөрчлөлт бий болсон гэж үзэж байна. Үүнд:

- Чанарын тогтолцооны талаар нийт албан хаагч нэгдсэн ойлголттой болов.
- Нэгжүүд харилцан өөр хоорондоо аудит хийснээр ажлын онцлог, нөхцөл байдлыг илүү мэддэг болов.
- Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулав
- Байгууллагын нэгжүүдийн дүрмийг шинэчлэн батлуулав.
- Байгууллын хэмжээнд бүртгэх маягт, загварын жагсаалтыг баталж мөрдүүлэв.
- Албан хаагч бүр дундын цахим файлд өдөр тутмын ажлаа тэмдэглэж дотоод хяналтын орчинг сайжруулав.
- Харилцагч, сонирхогч талуудынхаа хэрэгцээ, шаардлагыг илүү нарийн тодорхойлсон.

2021 оны сүүлийн хагас жилд байгууллагын хэмжээнд дотоод аудитын төлөвлөгөө гарган батлуулж түүний дагуу хэлтэс бүрийн үйл ажиллагаанд дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулж сайжруулах саналуудын дагуу үйл ажиллагаагаа сайжруулж байна. Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартын талаарх ерөнхий сургалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Сургалт, судалгааны төвтэй хамтран цахим хэлбэрээр зохион байгуулж нийт 27 байгууллагын 164 удирдах албан хаагчдыг хамруулав.

**Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд болон нийгмийн үйлчилгээний барилгын стандартыг мөрдүүлэх тогтолцоог бий болгох /Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.5.1 дэх заалт/**

**ХОТЫН СТАНДАРТЫН БАРИМТ БИЧИГ**

Дээрх арга хэмжээний хүрээнд 22 бүлгийн 97 төрлийн хотын стандартын баримт бичгийг боловсруулах ажлыг 2020-2021 онд гүйцэтгэж холбогдох сэдэв агуулгын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа 53 байгууллагаас санал авч тусган сайжруулсан. Боловсруулсан баримт бичгүүдийн эхний ээлжийн 61 баримт бичгийг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр, дараагийн ээлжийн 36 баримт бичгийг 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдөр тус тус Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулсан.



Зураг 5. Зөвлөлийн хуралд танилцуулах үйл явц

Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгүүдийг нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх талаар НЗД-ын 2020 оны “Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг мөрдүүлэх тухай” А/456, 2021 оны “Стандарт мөрдүүлэх арга хэмжээний тухай” А/276 дугаар захирамжуудыг батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллав.




Зураг 6. Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичиг

Боловсруулсан бүх баримт бичгүүдийг байгууллагын албан ёсны цахим хуудас **www.standard.ub.gov.mn** болон олон нийтийн сүлжээнд ил тод хүртээмжтэйгээр мэдээллэсэн.

## ХОТЫН СТАНДАРТЫН ТОГТОЛЦОО

### Хууль, эрх зүйн үндэслэл

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдаж нийслэл хот нь орчны аюулгүй байдлыг хангуулахтай

холбоотой хотын стандартыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан мөрдүүлэх талаар шинэ зохицуулалт тусгагдсан. Хотын стандартын эрх зүйн үндсийг бий болгохын тулд хуулийн төсөлд тусгах саналыг боловсруулан хуулийн ажлын хэсэгт удаа дараа хүргүүлэн хамтран ажилласан.

**Уулзалт хэлэлцүүлэг**

Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх хүрээнд хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийн хэрэглээ, салбар чиглэл бүрээр хотын стандартыг боловсруулах, мөрдүүлэхэд хамтран ажиллах талаар Нийслэлийн нутгийн захиргааны дараах байгууллагуудын удирдлагуудтай санал солилцох уулзалтыг 2021 оны 08-09 дүгээр сард зохион байгуулав. Үүнд:

- Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар
- Нийслэлийн Аялал жуулчлалын газар
- Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
- Нийслэлийн Байгаль орчны газар
- Нийслэлийн Боловсролын газар
- Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
- Нийслэлийн Орон сууц дэд бүтцийн газар
- Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
- Нийслэлийн Соёл Урлагийн газар
- Нийслэлийн Спорт хороо



Зураг 7. Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичиг хүлээлгэн өгч байгаа нь

Нийт 61 төрлийн хотын стандартын баримт бичгийг 16050 хэвлүүлсэнээс 9800 гаруй хувийг холбогдох нутгийн захиргааны байгууллагуудын хэрэгцээнд актаар хүлээлгэн өгөв.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай" А/828 дугаар захирамжийн хүрээнд НИТХ-ын тогтоолоор батлагдах "Хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх журам"-ын төсөл, НЗД-ын захирамжаар батлагдах "Хотын стандартын зөвлөлийн дүрэм"-ын төслийг тус тус боловсруулан НЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст хянуулахаар 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 01-03/537 дугаар албан бичгээр хүргүүлэв.



Зураг 8. Саравч сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага




Зураг 9.Гадна сурталчилгааны байгууламжид тавигдах шаардлага




Зураг 10. Худалдаа үйлчилгээний гадна орчин




Зураг 11. Орон сууцны дунд байрлах хүүхдийн тоглоомын талбай



Зураг 12. “Хог хаягдлын менежмент” бүлгийн 5 удирдамж арга зүйн баримт бичиг




Зураг 13. “Улаанбаатар хотын оршин суугчийн гарын авлага” удирдамж арга зүйн баримт бичгийн 6 дэд бүлэг

## Хөшөө дурсгал хүндэтгэлийн самбар

Соёл урлаг, түүхэн үйл явдлыг харуулсан, оюун сэтгэлгээний хөгжлийн илэрхийлэл болсон, архитектур, дүрслэх урлагийн шийдэл бүхий байгууламж буюу хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбарыг орон зайн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх,

байрлуулах, бүртгэх, үнэлэх, хамгаалах, арчлах, сэргээн засварлах, шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд удирдамж өгөх зорилгоор боловсруулсан бөгөөд баримт бичгийг уншиж судлан Герман улсын "Хөшөө дурсгал цэвэрлэгээ үйлчилгээ, арчилгаа" гарын авлагаас туршлага судлан хөшөө дурсгалын хийц материалуудын ангилал тус бүрээр нь цэвэрлэх аргуудыг баримт бичигт тусган боловсруулав.

## ХОЁР. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### 2.1 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их хурлын тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын дараах тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж ажиллав. Үүнд:

**Монгол Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын хэрэгжилт:**

Монгол Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол, Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчид олгох албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг өнгөрсөн оны саналуудтай харьцуулан боловсруулж Газрын удирдлагуудаар хянуулан баталж 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01-03/27 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц, удирдлагийн тасагт хүргүүлсэн.

2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" Нийслэлийн Засаг даргын А/270 дугаар захирамжийг хүлээн авсан. Уг захирамжаар 8 албан хаагчийн зэрэг дэв ахиулан олгогдсон. Захирамжийг газрын удирдлагад танилцуулан төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системд бүртгэн оруулж тухайн сараас эхлэн ахиулан олгогдсон зэргийн нэмэгдлийг албан хаагчдад олгож хувийн хэргийн баяжилт хийв.

**Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд:**

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг тэвчиж, цалингийн санд хэмнэлт үүсгэх зорилгоор шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, шаардлагатай орон тоог түр орлон гүйцэтгүүлэгчээр гүйцэтгүүлэн цалингийн зардалд 34.82 хувийн хэмнэлт гарган ажилласан байна.

**Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын биелэлтийг хангуулах ажлын хүрээнд:**

Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар"-ыг тус тус батлагдсаны дагуу Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/09 дугаар захирамжаар "Нийслэлийн 2021-2025 оны Стратеги төлөвлөгөө боловсруулах дэд ажлын хэсэг" байгуулагдсан. Тус ажлын хэсэгт Захиргааны хэлтсийн дарга Э.Даваахатан,Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга Н.Билэгсайхан нар ажиллаж холбогдох саналаа тусгаснаар Нийслэлийн Засаг даргын

2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/667 дугаар захирамжаар батлагдсан. Энэхүү захирамжтай нийцүүлэн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагааг Газрын даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг гүйцэтгэж байна. Байгууллагын мандатын шинжилгээ, орчны шинжилгээг гүйцэтгэж дууссан. Байгууллагын бүтэц, чиг үүрэг шинэчлэгдсэний дараа стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

**Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:**

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу Байгууллагын 2021 оны 29 зорилт 69 зүйл бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг:

- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд
- Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд
- Цаг үеийн асуудлын хүрээнд
- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд гэсэн 5 чиглэлээр гарган сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гариг бүр НЗДТГ-т тайлагнав.

**Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:**

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2-д заасны дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад ороход бэлэн болсон барилга байгууламж, гадна засвар, тохижилт, шинэчлэлт, инженерийн шугам сүлжээний ажлыг ашиглалтад оруулах бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж 2021 оны 11 дүгээр сараас эхлэн ажиллаж байна.

Дээрх дүрмийн дагуу хотын Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/682 дугаар захирамжаар барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын захиалагчийн үүргийг тус газарт хариуцуулж шинэчлэн батлагдсан бүрэлдэхүүний барилгын комиссын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан ажиллаж байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааны дэлгэрэнгүйг уг тайлангийн 3 дугаар бүлэгт дэлгэрэнгүй дурдав.

## 2.2. НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

**Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн "Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хэрэглэгчийн эрхийг хамгаалж хүртээмжийг сайжруулах" тухай 13 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гишүүнээр ажиллаж дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хэрэглэгчийн эрхийг хамгаалж хүртээмжийг сайжруулах ажлыг хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын орлогч дарга О.Оджаргал гишүүнээр ажиллав.Ажлын хэсгийн ажлын хуваарь, төлөвлөгөөнд саналыг боловсруулан 2021 оны 05 сарын 14-ний өдөр ажлын хэсгийн цахим хуралд танилцуулан батлуулсан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу тус газраас төрийн үйлчилгээний байгууллагуудын барилгын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдалд судалгааг дүүргүүдийн ЗДТГ-уудтай хамтран хийж үр дүнг ажлын хэсэгт танилцуулсан.

**Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/25 дугаар захирамжийн хэрэгжилт:**

Баянгол дүүргийн 13 дугаар хороо, 3 дугаар хороолол, Хасбаатарын гудамжны 10А, 11А, 11 дүгээр байрны авто замын орох, гарах урсгалыг хааж, оршин суугчдын хэвийн амьдрах нөхцөлийг хөндөж буй асуудлыг судалж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсэгт Хэлтсийн дарга Н.Билэгсайхан ажиллав.

Тус байрнуудын оршин суугчид болон DHT компани хоорондын авто машины зогсоолын маргаан, гомдлын дагуу 2 сарын хугацаанд ажилласны үр дүнд 20 автомашины зогсоол гаргаж, оршин суугчдыг зогсоол ашиглах боломжоор хангаж өгснөөр хүүхдийн тоглоомын талбайг чөлөөлсөн.

## 2.3.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

### 2.3.1. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус газар нь дүрмээр хүлээсэн чиг үүрэг, нийслэлийн удирдлага, нийслэлийн онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд 2021 онд дараах 10 захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Үүнд:

**Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/456, 2021 оны "Стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх арга хэмжээний тухай" А/276 дугаар захирамжийн хэрэгжилт:**

Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилгоор хот байгуулалт, хот нийтийн аж ахуйн салбарт улс, нийслэл, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнүүдэд стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгүүдийг мөрдүүлэх талаар голлох дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

- Хотын стандартын удирдамж аргазүйн талаар нэгдсэн ойлголт өгөх сургалт, зөвлөгөөн;
- Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгүүдийг олон нийтэд мэдээлэх, түгээх;
- Худалдан авах ажиллагааны баримт бичиг, техникийн даалгаваруудад стандартыг тусгуулах;
- Стандарт, нормыг мөрдөх талаар заавар, зөвлөн туслах арга хэмжээ

**Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/108, А/161, А/87 дугаар захирамжийн хэрэгжилт:**

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллав.

- Халдвар хамгаалал, хорио цээрийн дэглэмийг баримтлан, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, нийт албан хаагчдын 10-15 хүртэлх хувийг ажлын байранд ажиллуулах албан хаагчдын нэрсийг гаргаж халдвар хамгаалллыг хэрэгслийн нөөц бүрдүүлж, ажлын байранд тогтмол ариутгал халдваргүйжүүлэлт хийв.
- Цахимаар ажиллаж буй албан хаагчдын ажлын гүйцэтгэлд газрын даргын 2020 оны “Зайнаас /онлайн горимоор/ ажиллах түр журам батлах тухай” тушаалын дагуу /Google sheet/-ээр тогтмол хяналт тавьж ажиллав.

**Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1358 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/05 дугаар тушаалын хэрэгжилт:**

Чингэлтэй болон Налайх дүүргийн түвшин тогтоох үзлэг шалгалт явуулах дэд ажлын хэсэгт 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 15 ны өдрийн хооронд 78 Сууц өмчлөгчдийн холбоодын явган хүний зам, гэрэлтүүлэг, сандал, хогийн сав, дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, хашаа хайс гэсэн 7-н шалгуураар үзлэг шалгалт хийж ArcGIS программ дээр байршлыг тэмдэглэж, стандартын хэрэгжилтийг хангаж буй талаар дүгнэлт гарган ажлын хэсгийн тайланд тусгуулж ажиллав.




Зураг 14. Хяналт шалгалт хийж буй явц

**Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 тоот захирамжийн хэрэгжилт:**

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” А/06 дугаар захирамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг QR код ашиглан бүртгэх систем-ийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад дагаж мөрдүүлэх, халдвар хамгааллын дэглэм буюу биеийн халуун хэмжигч, гар ариутгагч, гар бичмэл хийх болон анхааруулга тэмдэг, тэмдэглэгээ хийсэн эсэхэд хяналт тавих ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 26-ний өдрөөс 2021 оны 02 дүгээр сарын 06-ний өдрийг хүртэл тухайн байршил дээр ажиллав.

**Иргэдийн амьдрах орчныг сайжруулах зарим арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/177 дугаар захирамжийн хэрэгжилт;**

Захирамжийн дагуу нийслэлийн 9 дүүрэгт дэд ажлын хэсэг байгуулагдаж Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн барилга угсралтын талбайн түр хашааг стандарт норм, дүрэмд нийцүүлэх, нэгж талбараасаа илүү талбайг хашаалсан хашаа хайсыг татуулах, нийтийн эзэмшлийг гудамж, зам талбай дахь орц, гарц, явган хүний замыг хааж, хөдөлгөөнд саад учруулж буй байршлуудын зөрчлийг арилгах мөн ил задгай кабелийн болон цахилгааны утасны аюулгүй байдлыг хангуулах зөрчлийг арилгах, өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн самбаруудыг цэгцлэх, стандарт норм, дүрмийг мөрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр холбогдох байгууллагуудын 117 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр газар дээр нь ажиллаж, зөрчлийг арилгуулах зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна. Үүнд:

1. Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд барилга угсралтын талбайн түр хашааны стандартыг хангуулах шаардлагатай нийт **307** түр хашаа байгаагаас **260** байршилд стандартад нийцүүлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай хугацаатай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн ба үүнээс **31** /10 хувь/ барилгын түр хашааг шинэчлүүлсэн.



*Зураг 15. Барилгын түр хашааг шинэчлүүлсэн байдал*

2. Нэгж талбараасаа илүү талбайг хашаалсан хашаа, хайсыг татуулах шаардлагатай урьдчилсан байдлаар **161** байршил байгаагаас зөрчлөө арилгах тухай хугацаатай мэдэгдэл хүргүүлэн сонсох ажиллагаа явуулан, **28** байршил /17%/-д зөрчлийг арилгуулсан.

3. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай дахь орц гарц, явган хүний замыг хааж, хөдөлгөөнд саад учруулж байгаа нийт **132** байршлаас **74** байршил /56%/-д зөрчлийг арилгуулан, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлүүлсэн.



Зураг 16. Орц, гарц хаасан зөрчлийг арилгуулсан байдал

4. Ил задгай кабелийн болон цахилгааны утасны аюулгүй байдлыг хангуулахаар илэрсэн нийт **477** байршлаас **186** байршил /39%/-д газар дээр нь цэгцэлж, засварлан аюулгүй байдлыг хангуулсан.



Зураг 17. Ил гарсан цахилгааны утасны аюулгүй байдлыг хангуулсан байдал

5. Өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн самбар, хаалт, хашлагуудыг цэгцлэх шаардлагатай нийт **787** байршлаас нийт **689** /88%/-д зөрчлийг арилган, цэгцлүүлсэн.




Зураг 18. Өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн самбар буулгасан байдал

6. Стандартын шаардлага хангахгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн хүүхдийн тоглоомын талбайн **401** байршилд байгаагаас **113** байршил /28%/-ын хүүхдийн тоглоомын талбайг засаж, сайжруулан зөрчлийг арилган ажилласан.





Зураг 19. Хүүхдийн тоглоомын талбай дахь зөрчлийг арилгуулсан байдал

Нийт орчны аюулгүй байдал алдагдсан зөрчил байгаагаас **2265** байршилд зөрчлөө арилгах тухай хугацаатай мэдэгдэх хуудас хүргүүлж, **1121** байршилд зөрчлийг арилгуулан ажилласан. Уг захирамжийн хэрэгжилтийн явц 50%-тай явагдаж байна.

Уг захирамжийн хэрэгжилтийн 7 хоног бүрийн тайлан дүн мэдээг 9 дүүргийн дэд ажлын хэсгийн харийн бичиг нараас авч нэгтгэн газрын удирдлагуудад танилцуулж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны zaa.audit@gmail.com цахим шуудангаар хүргүүлэн ажилласан. Мөн 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах танилцуулга болон хурлын тэмдэглэлийн төслийг боловсруулан Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэнд хүргүүлсэн.

**“Эко орчин-цэвэр агаар” аян зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/374 дүгээр захирамжийн хэрэгжилт;**

Нийслэлийн нутаг дэвсгэрт агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээг бодитой үр дүнд хүргэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор “Эко орчин-цэвэр агаар” аяныг зарлаж түүнийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын даргад орсон.

Байгууллагын зүгээс  ажлын хэсгийн 2 удаагийн хуралд оролцож Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдийн дунд “Налуу замтай-Иргэдэд ээлтэй” жишиг гудамжийг байгуулах уралдааны гудамжийг байгуулах удирдамжийг Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч З.Төмөртөмөөгөөр батлуулсан.

Удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 18-р хороо, Баянзүрх дүүргийн 16, 22-р хороонд иргэдийн оролцоотой хийгдэх тохижилтын ажлыг зураг төсөл боловсруулах талаар зөвлөмж зааврыг 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдөр аянд оролцогч 50 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлд газар дээр нь өгч ажиллав.







Зураг 20.Иргэдийн оролцоотой тохижуулах байршилд зөвлөгөө өгч ажиллав.

**Иргэдийн амьдрах орчныг сайжруулах зарим арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/375 дугаар захирамжийн хэрэгжилт;**

Орчны бохирдол үүсгэсэн, газар шорооны ажил дутуу хийгдэж удаан хугацаанд ухсан нүхтэй, овоолсон шороотой, эвдэрч нурсан хашаатай нийт 43 байршлын мэдээллийг нэгтгэж 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд “Орчны аюулгүй байдлын талаарх хийгдсэн судалгаа, 2021 онд хийгдэх тохижилтын ажлууд болон цаашид хэрэгжүүлэх орчны аюулгүй байдлын мэдээллийн сан үүсгэн ажиллах тухай” танилцуулах танилцуулгыг бэлтгэн ажиллав.



Зураг 21. 2021 оны 04 дугаар сарын 03 -ны өдөр Хан-Уул, Баянгол, Чингэлтэй дүүрэг байршлууд

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 05 дугаар хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн нутаг дэвсгэрт орчны бохирдол үүсгэсэн, газар шорооны ажил дутуу хийгдэж удаан хугацаанд ухсан нүхтэй, овоолсон шороотой, эвдэрч нурсан хашаатай байршлуудад газрын зөрчил арилгуулах талаар хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, Улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан орчны аюулгүй байдлыг хангуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг А/375 дугаар захирамжаар байгуулсан. Тус захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хуралдааныг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хурлын А танхимд 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 8 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, хуралдааны тэмдэглэл хөтөлж ажлын хэсгийн дарга болон гишүүдэд хүргүүлсэн.



Зураг 22. Ажлын хэсгийн хурал

Хуралдааны шийдвэрийн дагуу Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга Н.Мөнхбаяр, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Т.Орхон, Хот байгуулалт, хөгжлийн газраас ирүүлсэн мэдээллийг нэгтгэж Ажлын хэсгийн даргад танилцуулсан.

**Иргэдийн амьдрах орчныг сайжруулах зарим арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/376 дугаар захирамжийн хэрэгжилт;**

Иргэдийн амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй дутуу баригдсан барилгын судалгааг 2021 оны 04 дүгээр сард гарган дараах жагсаалтыг гарган Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар танилцуулсан. .

- Сургууль, цэцэрлэгийн царцсан барилгын 28 байршил,
- Газрын эрхийг цуцлах шаардлагатай 29 байршил,
- Барилгын суурийн нүх ухсан - 17 байршлуудад



Зураг 23. Газрын эрхийг цуцлах байршлуудад ажилласан нь

Дээрх хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу газрын эзэмших гэрээнд заасан, нөхцөл, болзлыг биелүүлээгүй, гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүйгээс тухайн орчны аюулгүй байдлыг алдагдуулсан байршлуудад газрын зөрчлийг арилгуулах, газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, тухайн байршлуудыг нийтийн эзэмшлийн зориулалтаар төлөвлөх ажлыг зохион байгуулах үүрэг чиглэл бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Тус ажлын хэсгийн хуралдаан 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Хангарди ордны 14 дүгээр давхрын А танхимд болж Газрын дарга С.Төмөрдулам болон Хэлтсийн дарга Н.Билэгсайхан нар оролцож, тус хурлаар газрын эрхийг цуцалж, нийтийн эзэмшлийн зам талбайгаар тохижуулах санал бүхий 32 байршлын мэдээлэл өгсөн.




Зураг 24. Зөрчилтэй байршлын жагсаалт

Үүний дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалт зохион байгуулж 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 02-04-127/707, 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 02-02/2330 тоот улсын байцагчийн дүгнэлт мэдээллийг ирүүлсэн. Үүнд нийт 75 байршлын 37 байршил хамрагдсан.

**Нийслэлийн Засаг даргын "Хяналт шалгалт хийх тухай" А/690 дүгээр захирамжийн хэрэгжилт:**

Нийслэл хотод 2021 онд Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудын гүйцэтгэл, үр дүнд хяналт шалгалтыг зохион байгуулах, нэгдсэн удирдлага арга зүйгээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Х.Гантулгаар ахлуулан байгуулж хяналт шалгалтын удирдамжийг баталсан.

Хяналт шалгалтын ажлыг салбар, чиглэлээр нь 5 ангилан тус бүрийг хариуцсан дэд ажлын хэсгүүдийг байгуулагдаж Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын дарга, удирдлагууд, мэргэжилтнүүдийн нийт 14 албан хаагч холбогдох чиглэлээр хяналт шалгалтын ажилд оролцсон. Үүнд:

Хүснэгт 1. Ажлын хэсэгт оролцсон байдал

| № | Дэд ажлын хэсгийн чиглэл | Ажлын хэсгийн ахлагч | Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газраас ажилласан төлөөлөл |
|---|---|---|---|
| 1 | Авто зам, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, гадаадын төсөл, хөтөлбөр | Ш.Батшагай /НМХГ-ын дэд дарга | С.Билгүүн /СХХ-ийн мэргэжилтэн/<br>Ц.Нямцэвээн /ББХХ-ийн мэргэжилтэн/ |
| 2 | Сургууль, цэцэрлэг, олон нийтийн зориулалттай барилга байгууламжийн ажил | С.Төмөрдулам /ХСОАБХЗГ-ын дарга/ | Ц.Тогтохбуян /ББХХ-ийн ахлах мэргэжилтэн/<br>Б.Хулан /МТХ-ийн мэргэжилтэн/ |
| 3 | Тохижилт, цэцэрлэгжилт, ногоон байгууламжийн хүрээнд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажил | Б.Алтантуяа /НМХГ-ын дэд дарга/ | Н.Билэгсайхан /ОАБХХ-ийн дарга/<br>Б.Ундармаа /ОАБХХ-ийн мэргэжилтэн/<br>У.Санчир /ОАБХХ-ийн мэргэжилтэн/ |
| 4 | Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан захирамжийн хэрэгжилт, газрын зөрчил арилгах, цуцлах ажил | Х.Гантулга /НЗДТГ-ын ХШҮХ-ийн дарга/ | Д.Өлзийсайхан /ОАБХХ-ийн ахлах мэргэжилтэн<br>Д.Номин /ОАБХХ-ийн мэргэжилтэн/ |
| 5 | Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн засвар шинэчлэлийн хүрээнд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажил | О.Оджаргал /ХСОАБХЗГ-ын орлогч дарга/ | П.Мөнхзаяа /СХХ-ийн мэргэжилтэн/<br>Б.Өсөх-Идэр /БТХ-ийн мэргэжилтэн/<br>А.Энхзаяа /МТХ-ийн мэргэжилтэн/ |

Дээрх дэд ажлын хэсгүүдэд тус газрын албан хаагчид оролцож хяналт шалгалтын чиглэл бүрээр ажлын төлөвлөгөө боловсруулах, батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтын ажлын байршил дээр ажиллаж бодит нөхцөл байдлыг судалж дүгнэлт гарган ажилласан ба дараах мэдээлэл, тайланг тухай бүр гарган ажлын хэсгийн даргыг мэдээллээр хангаж ажилласан.

Хяналт, шалгалтын ажлын үр дүнг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2021 оны 10 дугаар сард танилцуулсан бөгөөд тус газрын албан хаагчид дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Тохижилт, цэцэрлэгжилт, ногоон байгууламжийн хүрээнд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, үр дүнг шалгах" дэд ажлын хэсэг Нийслэлийн 9 дүүргийн нийт 61 байршилд хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллав. Ажлын хэсгийн илтгэх хуудасны төслийг боловсруулж ажлын хэсгийн нарийн бичгийн дарга НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсийн мэргэжилтэн М.Мөнхтуулд 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хүргүүлэв.
- Нийслэлийн 9 дүүргийн 135 байршилд газрын зөрчилтэй холбоотой захирамжийн гүйцэтгэл, үр дүнг газар дээр нь шалган ажиллав. Хяналт шалгалт хийхэд 107 байршлын зөрчлийг арилгаж, газрыг чөлөөлсөн ба 28 байршилд 71 зөрчлийг илрүүлэв. Ажлын хэсгийн илтгэх хуудасны төслийг боловсруулж Ажлын хэсгийн ахлагч НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсийн дарга Х.Гантулгаар баталгаажуулав.
- Газрын дарга С.Төмөрдуламаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуваарийн дагуу нийт 80 байршилд барилга байгууламжийн ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавин ажиллав. Үүнд: 19 сургууль , 14 цэцэрлэг, 3 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, 2 сургуулийн барилга худалдаж авах, 3 цэцэрлэгийн барилга худалдаж авах, олон нийтийн зориулалттай баригдаж буй 39 барилга байгууламжийн нийт 80 ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавин ажиллалаа.
- НМХГ-ын Дэд дарга Б.Батшагайгаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нийт 23 байршилд ажлын явц, гүйцэтгэлд хяналт шалгалт явуулж ажиллав.
- Газрын Орлогч дарга О.Оджаргалаар ахлуулсан дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн төлөвлөгөө, хуваарийн дагуу Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нийт 15 байршлын ажилд хяналт тавьж ажиллав.Үүнд: 5 сургууль, 5 цэцэрлэг, 3 эрүүл мэндийн байгууллага, 2 их засвар шинэчлэл, тоног төхөөрөмжийн ажил дээр тус тус хяналт тавьж ажиллав.

### 2.3.2 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

**Нийслэлийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн "Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр авах зарим хэмжээний тухай 02 дугаар албан даалгаврын хэрэгжилт:**

Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгаврын 8 дахь заалт "Хүүхдийн тоглоомын талбайн MNS 6751:2019 стандартын хэрэгжилтийг хангуулах, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бий болгох" үүрэг даалгаврын дагуу тус газар нь 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэл дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Хүүхдийн тоглоомын талбайн MNS 6751:2019 стандарт, UCS0002-02:2019 "Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага" баримт бичгийн шалгуурын дагуу нийт 30 үзүүлэлтээр хүүхдийн тоглоомын талбайн стандарт хангагдаж байгаа эсэх талаар шалгах хуудсыг боловсруулан нийслэлийн 9 дүүргийн 171 хороодоос судалгаа авахад нийт 141 хорооны 976 хүүхдийн тоглоомын талбай судалгаанд хамрагдаж дүн мэдээг нэгтгэж ажилласан.

График 1. Дүүргүүдийн тайлан ирүүлсэн байдал







График 2. Хүүхдийн тоглоомын талбайн төрлөөр

Хүүхдийн тоглоомын талбайг төрлөөр нь ангилж үзвэл:

Нийт 976 хүүхдийн тоглоомын талбайгаас

- Хүүхдийн тоглоомын талбай- **786**
- Чийрэгжүүлэлтийн талбай- **88**
- Сагсны талбай- **75**
- Хөл бөмбөгийн талбай- **6**
- Бусад /дан саравч, дан гулсуур зэрэг/- **17** хүүхдийн тоглоомын талбайг тохижуулсан байна.

График 3. Төлөвлөлт тохижилтын стандарт шаардлага хангасан байдал



Тус судалгаанаас үзэхэд тайлан ирүүлсэн нийт 9 дүүргийн 141 хорооны 976 тоглоомын талбайн 37,5% нь тоног төхөөрөмжийн бүрдэл хэсэг эвдэрсэн, алга болсон, 37,8% нь элэгдэж муудсан холбоостой, 29,9% нь түгжээ бэхэлгээ алдагдаж, 9% -д нь ил гарсан цахилгааны утас зэрэг аюултай нөхцөл байдал үүссэн байна. Иймд нийслэлийн нутаг дэвсгэр дэх тоглоомын талбайн тал хувь нь стандартын шаардлага хангаагүй, хүүхдийн эрүүл мэндэд аюул учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн байна.

Судалгаагаар илрүүлсэн засварлах, шинэчлэх шаардлагатай тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангуулах ажлыг яаралтай зохион байгуулах, 2021 оны төсөл арга хэмжээтэй уялдуулан ажиллуулах тухай албан бичгийг судалгааны үр дүнгийн хамт 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, судалгааны дүнг 2021 оны 06 дугаар сарын 04-ний нэгтгэв.

## 2.4.НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССООС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

**Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар цахим хурлын тэмдэглэлийн шийдвэрийн хэрэгжилт;**

Нийслэлийн хэмжээнд Коронавирус /Ковид-19/ халдварын тохиолдол хурдацтай нэмэгдэж хүн амын дунд тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улс, Нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан хуваарийн дагуу 2021 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийг дуустал 09:00-18:00 цагийн хооронд Сүхбаатар дүүргийн 15,17,19 дүгээр хороодод хуваарилагдан хорооны нутаг дэвсгэрт тогтоосон цэгт шинжилгээндээ хамрагдах эрүүл мэндийн байгууллагад хандах, хүнсний дэлгүүр, усан сан худаг орохоос бусад нөхцөлд гэрээсээ гарахгүй байх, мөн халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх талаар нийт 825 иргэн, авто машинаар хөдөргөөнд оролцож буй иргэдэд тус тус заавар, зөвлөмж өгч ажилласан ба тухайн эргүүлээр ажилласан өдөр бүрийн тайлан мэдээг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын тамгын газрын тухайн өдрийн эргүүлийн мэдээг хариуцсан албан хаагчид цаг тухай бүр өгч ажиллав.




Зураг 25. Эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажилласан байдал

2021 оны 05 дугаар сарын 22-ны өдөр "Шуурхай штабт хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах тухай" Нийслэлийн Онцгой комиссын даргын тушаалын дагуу Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээ зохион

байгуулах, эрсдэлийг бууруулах, шуурхай ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабт хариуцлагатай жижүүрээр ажиллах хуваарийн дагуу Сонгинохайхан дүүргийн эмээлт товчоонд Улс, нийслэл, дүүргийн онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж, Шуурхай штаб болон газрын удирдлагыг цаг үеийн мэдээ мэдээллээр хангаж жижүүрийн үүрэг гүйцэтгэж ажиллав.




Зураг 26. Эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй явц

Коронавируст халдвар нийтийн дунд шилжиж өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан газрын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу нийт албан хаагчдыг 2 удаа халдвар илрүүлэх PCR шинжилгээнд хамруулсан.

**Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны “Шуурхай штабт хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах тухай” 10 дугаар тушаалын хэрэгжилт:**

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээ зохион байгуулах, эрсдлийг бууруулах, шуурхай ажиллагааг хангах зорилгоор тус газрын дарга С.Төмөрдулам 2021 оны 04 дүгээр сарын 04,18 болон 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэж дараах арга хэмжээг авч ажиллав.

- Дүүргүүдийн шуурхай штабын үйл ажиллагааг шалгах
- Хариу арга хэмжээ, тандалтын багуудын үйл ажиллагааны хүртээмж, зохион байгуулалтанд заавар, зөвлөмж өгөх
- Цар тахлын халдварын нөхцөл байдлын талаар цаг үеийн мэдээллийг нэгтгэх, нийслэлийн онцгой комиссын удирдлагыг мэдээллээр хангах
- Шалгах нэвтрүүлэх товчооны үйл ажиллагаа, халдвар хамгааллын нөхцөл байдалд хяналт шалгалт хийх
- Дархлаажуулалтын цэгүүдийн бэлэн байдлыг нягтлах




Зураг 27. Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штаб

**Албан хаагчдыг цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагаа**

Цар тахлын халдвараас албан хаагчдыг хамгаалах, урьдчилан сэргийлэхийн тулд албан хаагчдыг вакцинжуулалтад хамруулах, ажлын байрны ариутгал халдваргүйтгэл хийлгэх арга хэмжээг шаардлагатай үед тогтмол зохион байгуулж ажиллав.

**Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдсан байдал**

| № | Вакцинжуулалт | Хамрагдсан албан хаагчдын тоо | Хувь | Огноо |
|---|---|---|---|---|
| 1 | 1-р тун | 42 | 100% | 2021.03.15 |
| 2 | 2-р тун | 42 | 97,5 | 2021.04.23 |
| 3 | Нэмэлт буюу 3 дахь тун | 35 | 87,5 | 2021.09.04 |

- Ажлын байранд болон гадуур ажилласан албан хаагчдад халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор амны хаалт, гар ариутгагч болон гарын саван зэрэг хэрэгцээт зүйлсийг худалдан авч нөөц хангасан.
- Цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд халдвар хамгааллын дэглэм сахиулж иргэд, ААНБ-д үйлчилгээ үзүүлж ажиллах 03, 04, 05 дугаар сарын албан хаагчдын жижүүрийн хуваарь гаргаж батлуулан, үүдний хаалт хийлгэсэн.

**Ковидын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэв.**

Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдөр баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас коронавирусын халдварын үеийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн ажиллах хуваарь"-ийн дагуу тус газрын нийт 21 албан хаагч Хан-Уул дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2021.10.03-2021.11.03-ийг хүртэл ажиллаж дараах үүргийн гүйцэтгэв.

Эмийн багц савлах



Эмчилгээний багийн жолоочоор ажиллах



Зураг 28. Хан-Уул дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэг үзүүлэх явц



Дүн мэдээ, бүртгэл хөтлөх



Иргэдийн дуудлага мэдээлэлд хариу өгөх

**Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 15 дугаар тушаалыг хэрэгжүүлэх**

Нийслэлийн Онцгой комиссын даргын тушаалын дагуу Сайжруулсан түлшний түгээлт борлуулалт, Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх тарилгын ажилд батлагдсан хуваарийн дагуу Сүхбаатар дүүргийн 15,17 дугаар хороонд сайжруулсан түлшний хэрэглээ, борлуулалт, түгээлтийн үйл ажиллагаа, мөн дүүргийн 4,10 дугаар хороодод Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэн нэмэлт буюу 3 дахь тунгийн хамрагдалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд тус газрын ОАБХХ-ийн дарга Н.Билэгсайхан, мэргэжилтэн Д.Мөнх-Эрдэнэ, БТХ-ийн мэргэжилтэн Б.Дуламдорж, МТХ-ийн мэргэжилтэн А.Энхзаяа нар өдөр тутам ажиллаж байна.




Зураг 29. Эргүүлээр ажиллаж буй явц

## ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

### 3.1. ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУДАЛГАА ХИЙХ

**Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын судалгаа:**

Улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2021 он дамжин хийгдэх болон 2021, 2021-2022 онд Нийслэлийн хэмжээнд хийгдэх тохижилт бүтээн байгуулалтын ажилд стандартын шаардлагуудыг хангуулах, удирдамж арга зүйгээр хангах болон бүтээн байгуулалтын ажлын давхардал арилгах зорилгоор тус онд хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг нэгтгэсэн.

2021 онд Улс, Нийслэл, Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам, бүтээн байгуулалт, тохижилтын ажил, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна талбайн тохижилтын чиглэлээр Нийслэлийн **9** дүүрэгт **791,592** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **831** ажил төлөвлөгдсөнөөс 2021 онд **40.7%** буюу **322,540** тэрбум төгрөгөөр санхүүжиж хэрэгжсэн.

Эдгээр ажилд Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичгүүдээс нийт **35** стандартыг мөрдөн ажиллах шаардлагатай тул тэдгээрийг үйл ажиллагаандаа мөрдүүлэх талаар зөвлөн туслах арга хэмжээг газрын даргын 2021 оны "Удирдамж арга зүйгээр хангах тухай" А/25 дугаар тушаалын дагуу гүйцэтгэсэн.




График 4. Нийслэлийн 9 дүүргээс ирүүлсэн судалгааны дүн

**Хороо, өрхийн эмнэлгийн барилга хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын судалгаа:**

2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн 171 хорооны барилгын гадна орчинд тэргэнцэртэй иргэдэд зориулсан налуу замтай эсэх судалгаа болон Сууц өмчлөгчдийн холбооны гадна орчны судалгааг ирүүлэх тухай 01-06/111 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Нийслэлийн 9 дүүргийн 171 хорооноос **161** хорооны судалгааг нэгтгэж танилцуулав.

Тус судалгаанаас үзэхэд судалгаа ирүүлсэн **161** хорооноос **90** хороо буюу **62%** нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу замтай боловч түүнээс шаардлага хангаж байгаа нь **48** хороо буюу нийт судалгаа ирүүлсэн хорооны ердөө **30%** нь Хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилга хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байна гэсэн судалгааны дүн гарч байна.




График 5. Стандартын шаардлага хангасан эсэх талаар судалгааны дүн

Хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын судалгааны дүнд тэргэнцэртэй иргэдэд зориулсан налуу замын **70%** нь шаардлага хангахгүй, сайжруулах шаардлагатай байна гэсэн үр дүн гарсан.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 13 дугаар захирамжаар байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хэрэглэгчийн эрхийг хамгаалж хүртээмжийг сайжруулах талаар авах арга

хэмжээний тухай асуудлуудыг судалж, санал дүгнэлт гаргах” ажлын хэсэгт судалгааны үр дүнг хүргүүлсэн.

**Сууц өмчлөгчдийн холбооны гадна орчны судалгаа:**

Нийслэлийн 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа Сууц өмчлөгчдийн холбооны гадна орчны судалгааг авахаар дараах **7** шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Судалгаанд нийт **1154** Сууц өмчлөгчдийн холбоо хамрагдсан.




*Зураг 30.Шалгуур үзүүлэлт*

Нийслэлийн 9 дүүргийн Сууц өмчлөгчдийн холбооны гадна орчны судалгаанаас үзэхэд шаардлага хангаж байгаа **587**, сайжруулах шаардлагатай **345**, шаардлага хангахгүй **222** байна. Судалгаа ирүүлсэн СӨХ-ны **51%** нь шаардлага хангаж байгаа бол **49%** нь сайжруулах шаардлагатай болон хангалтгүй гэж үнэлэгдсэн.

**Зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын үйл ажиллагааны судалгаа /Нийт 116 барилгын жагсаалт/**

Нийслэлийн хэмжээнд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй, стандарт, норм зөрчиж барилга барьж байгаа талаар судалгаа явуулахад нийслэлийн хэмжээнд 116 барилга бүртгэгдсэн.



Зураг 31. 2021 оны 03 дугаар сарын 05 -ны өдөр

**Яаралтай тусламжийн /Эмнэлэг, онцгой байдал, цагдаа/ ажил үйлчилгээнд саад учруулж буй хүчин зүйлийн талаар судалж, судалгаагаар илэрсэн саадыг /хашаа, объектыг чөлөөлүүлэх/ арилгах, иргэдийн тусламж үйлчилгээ авах**

**эрхийг хангах, хот төлөвлөлтийн норм дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд;**

2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Нийслэлийн Тээврийн цагдаагийн газраас ирүүлсэн 15-1/247 дугаар албан бичгийн дагуу Нийслэлийн хэмжээнд явган замыг нарийсгаж зорчих боломжгүй болгосон орц, гарц чөлөөлөх шаардлагатай 153 байршлаас 2021 оны 04 дүгээр сарын 21, 23-ны өдрүүдэд нийслэлийн 6 дүүргийн 101 байршилд хэлтсийн албан хаагчид газар дээр нь баталгаажуулж ажилласан.



Зураг 32. 2021 оны 04 дүгээр сарын 21, 23-ны өдөр

**Орчны аюулгүй байдал, стандарт, нормын талаар хийгдсэн судалгаа:**

Хүснэгт 2. Судалгааны дүн

| № | Судалгааны төрөл | Тоон үзүүлэлт | Үр дүн |
|---|---|---|---|
| 1 | Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчин | 256 | Нийслэлийн хэмжээнд улсын өмчийн **147** ерөнхий боловсролын сургууль, хувийн өмчийн **109** ерөнхий боловсролын сургууль нь стандартын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж буй үзүүлэлтээр судалгаа хийхэд нийт стандартын шаардлага хангаагүй **70** сургууль байгааг судалгаагаар гаргасан бөгөөд тухайн асуудлаар танилцуулга, мэдээллийг бэлтгэж 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар танилцуулж холбогдох Нийслэлийн Боловсролын газарт гадна орчны аюулгүй байдлыг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах үүрэг даалгавар өгөгдсөн. |
| 2 | Хүүхдийн тоглоомын талбай | 976 | 2019 оноос эхлэн Нийслэлийн хэмжээнд буй хүүхдийн тоглоомын талбайн судалгааг явуулж эхэлсэн бөгөөд 2021 оны байдлаар Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт **976** хүүхдийн тоглоомын талбай байгаагаас хүүхдийн эрүүл аюулгүй орчинд чөлөөт цагаа өнгөрүүлэх, тоглож наадахад эрсдэл учруулахуйц нөхцөл байдал үүссэн, стандартын шаардлага хангуулах шаардлагатай нийт **637** хүүхдийн тоглоомын талбай байгааг судалгаагаар гаргасан. Тухайн асуудлаар 2019, 2020, 2021 онуудад Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын тамгын газарт хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангуулах талаар удаа дараа албан бичгүүдийг хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 албан даалгавар, 2020 оны |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 12,13,14,15 дугаар хурлын тэмдэглэл, 2021 оны Нийслэлийн Засаг даргын А/177 дугаар захирамжуудаар хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өгөгдөж аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр тодорхой үр дүнтэй зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан. |
| 3 | Барилгын гадна орчны аюулгүй байдал | **307** | 2019 оноос эхлэн Нийслэлийн хэмжээнд барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэн явуулж буй иргэн, аж ахуй нэгжүүдэд барилга угсралтыг талбайн түр хашааны аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр судалгааг явуулж 2019-2020 онд стандартын шаардлага хангахгүй барилга угсралтын нийт **460** барилгын түр хашаанаас **341** барилгын түр хашааг стандартын шаардлагад нийцүүлсэн. 2021 онд нийт барилга угсралтын **307** түр хашаанаас **120** барилга угсралтын түр хашааг шинэчлүүлж аюулгүй байдлыг хангуулаад байна. |
| 4 | Тээврийн хэрэгсэл, явган хүний зорчих хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх байршлууд | **93** | Иргэдийн амьдрах орчныг сайжруулах зарим арга хэмжээ буюу авто зам, явган хүний замын орц гарц бий болгох, авто машины болон явган хүний хөдөлгөөнд саад учруулж буй хашаа, хайс, объектыг чөлөөлөх шаардлагатай байгаа Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд нийт **93** байршлын судалгаа гарган орц, гарцыг чөлөөлөх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг хангаж ажиллах тухай албан бичгийг Нийслэлийн газар зохион байгуулалтын алба болон Хот байгуулалт хөгжлийн газарт тус тус хүргүүлэн ажилласан. Нийт 93 байршлаас 2020 онд **11** байршилд газар чөлөөлөлт хийгдэж, одоогоор чөлөөлөх шаардлагатай **82** байршил байна. Уг асуудлаар мөн Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар танилцуулан ажилласан. |
| 5 | Хүүхдийн Цэцэрлэгийн гадна орчин | **205** | Нийслэлийн хэмжээнд **260** цэцэрлэг байгаагаас судалгаанд хамрагдсан 205 цэцэрлэгээс сайжруулах стандарт хангуулах шаардлагатай нийт **139** цэцэрлэг байгааг судалгаагаар гаргасан бөгөөд тухайн асуудлаар танилцуулга, мэдээллийг бэлтгэж 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар танилцуулж холбогдох Нийслэлийн Боловсролын газарт гадна орчны аюулгүй байдлыг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах үүрэг даалгавар өгөгдсөн. |
| 7 | Хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдал | **161** | Судалгаа ирүүлсэн **161** хорооноос **90** хороо буюу **62%** нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу замтай боловч түүнээс шаардлага хангаж байгаа нь **48** хороо буюу нийт судалгаа ирүүлсэн хорооны **30%** нь Хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилга хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байна гэсэн судалгааны дүн гарсан. Хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын судалгааны дүнд **113** хорооны налуу стандартын шаардлага хангахгүй, сайжруулах шаардлагатай байна гэсэн үр дүн гарсан. |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | СӨХ-ийн гадна орчин /орчны тохижилт, ногоон байгууламж, авто зогсоол/ | **1154** | Нийслэлийн 9 дүүргийн **1154** СӨХ судалгааны материал, фото зургийн хамт ирүүлсэн. 9 дүүргээс шаардлага хангаж байгаа нийт **587** СӨХ, сайжруулах шаардлагатай нийт **345** СӨХ, шаардлага хангахгүй нийт **222** СӨХ байна. Судалгаа ирүүлсэн СӨХ-ны 51% нь шаардлага хангаж байгаа бол **49%** нь сайжруулах шаардлагатай болон хангалтгүй байна. |
| 9 | Нийтийн тээврийн зогсоолын стандартын хэрэгжилт | **931** | Нийслэлийн хэмжээнд нийт **931** автобусны буудал байгаагаас Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба JCDecaux олон улсын байгууллагатай хамтран 2014-2019 онд **211** автобусны буудлыг стандартын дагуу тохижуулсан. 2021 оны байдлаар стандартын дагуу тохижуулах шаардлагатай нийт 720 автобусны буудал байгаа бөгөөд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд нийт **10** автобусны буудал тохижуулахаар гэрээ хийгдсэн. |
| 10 | Төвийн шугам сүлжээнд холбогдоогүй худалдаа үйлчилгээний байгууллагуудад нийтийн бие засах газрын стандартад нийцүүлэх, мөрдүүлэх | **3077** | Судалж байна. Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 382 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/995 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжгүй худалдаа, үйлчилгээний байгууллагуудад “MNS5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага”, Хотын стандартын баримт бичгүүдийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хэрхэн ашиглах сэдвээр сургалт, танилцуулгыг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 01-03/387 дугаартай албан бичгийг хүргүүлэв. Мөн 2021 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газраас зохион байгуулсан “Өнтэй өвөлжье” болон 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож "UCS0704B:2020 Бие даасан инженерийн дэд бүтэц. Бохир усны цооног, бие даасан цэвэрлэх байгууламж" баримт бичгийг иргэдэд сурталчлан таниулав. |
| 11 | Барилга угсралтын ажил зогссон сургууль, цэцэрлэгийн байршлуудын судалгаа | **23** | Нийслэлийн хэмжээнд 2020 онд хийгдсэн урьдчилсэн судалгаагаар барилгын ажил дутуу хийгдэн орхигдсон, хамгаалалтын хашаагүй, арматур төмөр зангидан ил задгай орчны аюултай байдал үүсгэсэн Ерөнхий боловсролын сургууль болон хүүхдийн цэцэрлэгийн царцсан **барилгын 23** байршил байна. |
| 12 | Орчны бохирдол үүсгэсэн, удаан хугацаанд ухсан нүхтэй, овоолсон шороотой, эвдэрч нурсан хашаатай газрын байршлууд | **43** | Орчны бохирдол үүсгэн удаан хугацаанд ухсан нүх, овоолсон шороо, эвдэрч нурсан хашаатай 43 байршил болон Нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмших гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлээгүй, гэрээнд заасан зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй 32 байршлын судалгааг гаргаж нийт **75** байршилд улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан 37 байршилд газрын тухай хуулийн 40.1 дэхь заалтын дагуу нийтийн эзэмшилд авч тохижуулах саналыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас боловсруулж байна. |
| 13 | Нийтийн эзэмшлийн талбайгаар тохижуулах боломжтой байршлын судалгаа | **32** | |

## 3.2. ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ

Хан-Уул, Баянгол, Чингэлтэй дүүргүүдийн нийт 5 байршилд Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ж.Сандагсүрэн, Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга Н.Билэгсайхан болон Нийслэлийн Боловсролын газрын холбогдох албан хаагчид үзлэг хийв.

2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн /цахим/ дээр өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу орон сууцны хотхон, хороололлуудын дундах орц гарцны асуудалтай холбоотойгоор www.manaikhoroo.mn цахим систем /иргэдийн амьдрах орчны ерөнхий зураглал, тухайн орчинд үүсээд буй зөрчлийн мэдээллийг бүртгэж, холбогдох байгууллагад хувиарлан шийдвэрлэх систем/ дээр ирүүлсэн зөрчлийг арилгахаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай албан бичгийг Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэв.

## 3.3. ХОТЫН СТАНДАРТЫН УДИРДАМЖ АРГА ЗҮЙГ БОЛОВСРУУЛАХ, МӨРДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10 дугаар сарын 31 -ний өдрийн 28/27 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" -ийн 2 дугаар бүлгийн 2 -т Хот байгуулалт, дэд бүтцийн салбарын эрх зүйн орчныг шинээр бүрдүүлж дэд бүтцийг хөгжүүлэх эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулалтыг хийж мөрдүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн хот төлөвлөлт, хот байгуулалт, барилга дэд бүтэц, хот нийтийн аж ахуйн салбарт хамаарах нийт 22 бүлэг сэдвийн хүрээнд 97 ширхэг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын баримт бичиг боловсруулахаар төлөвлөгдсөн.

2021 оны 04 сарын 21-ний өдөр Нийслэлийн Засаг даргын А/276 тоот Захирамж гарсанаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үр дүнг сайжруулах зорилгоор хот байгуулалт, хот нийтийн аж ахуйн салбарт улс, нийслэл, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээнүүдэд холбогдох стандарт, норм, дүрмийг мөрдүүлж хяналт тавихад хэрэглэгдэх удирдамж арга зүйн баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах тухай захирамж гарсан.

Тус захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад батлагдсан хуваарийн дагуу хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийн талаар сургалт орох, баримт бичгийн хэрэгжилтийг хангуулахаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зэрэг үйл ажиллагаануудыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Хэвлэлийн эх бэлтгэлд хүлээлгэн өгсөн баримт бичгүүд

Нийслэлийн Засаг даргын А/276 тоот Захирамж гарсанаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үр дүнг сайжруулах зорилгоор хот байгуулалт, хот нийтийн аж ахуйн салбарт улс, нийслэл, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээнүүдэд холбогдох стандарт, норм, дүрмийг мөрдүүлж хяналт тавихад хэрэглэгдэх нийт 43 удирдамж арга зүйн баримт бичгийг хэвлэлтэд оруулан бэлтгэв.




Зураг 33. Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичиг

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлн боловсруулан хэрэгжүүлэх" ажлын хүрээнд LRT буюу хөнгөн галт тэрэгний баримт бичгийн суурь судалгааг хийж байна. Суурь судалгааны агуулгад:

1. LRT буюу Хөнгөн галт тэрэг төлөвлөх ерөнхий шаардлага;
2. LRT буюу Хөнгөн галт тэрэгний төрөл, зориулалт, ангилал;
3. LRT буюу Хөнгөн галт тэрэг төлөвлөх зарчим;
4. Техник үзүүлэлтүүд.

Суурь судалгааг Монголд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, норм дүрэм, стандарт болон олон улсын баримт бичиг, туршлага судлаж байна. Үүнд:

1. NEW LIGHT RAIL TRANSIT SYSTEM COLOMBO /Жайка төсөл/;
2. Санта кларагийн хөнгөн галт тэрэгний үйлчилгээний гарын авлага;
3. Канадын Эдмонтон хотын хөнгөн галт тэрэгний гарын авлага ;
4. Хятадын хөнгөн галт тэрэг төлөвлөх стандарт GB /T51263 – 2017/.




Зураг 34. Суурь судалгаанд ашиглагдаж буй гадаад баримт бичгүүд

## 3.4. ХОТЫН СТАНДАРТЫН ТАЛААРХ ЗӨВЛӨГӨӨН, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Стандартын мэдлэг ойлголтыг сайжруулах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажлын үр дүн:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх арга хэмжээний тухай” А/276 дугаар захирамжаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, дүүргүүдийн засаг даргын тамгын газрын албан хаагчдад стандартын удирдамж арга зүйн баримт бичгийн талаар нэгдсэн ойлголт өгөх, хэрэгжилтийг хангуулах талаар сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх тухай үүрэг даалгаврын дагуу сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж Нийслэлийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Оюунчимэгээр батлуулав.

Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу Нийслэлийн Сургалт судалгааны төвтэй хамтран 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 12 удаагийн сургалтыг цахимаар зохион байгуулсан бөгөөд нийт **740** албан хаагч хамрагдав.




Зураг 35.Сургалтын үйл явц

## 3.5. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоолоор “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг шинэчлэн баталсанаар 2018 оны Засгийн газрын 317 дугаар тогтоол хүчингүй болсон. Дээрх тогтоолын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/862 дугаар захирамжаар Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн, Барилга байгууламжийн гадна тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсанаар барилга байгууламж болон Барилга байгууламжийн гадна тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж стандарт шаардлагад нийцүүлэн зохион байгуулан ажиллав. Үүнд:

**Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1022, 2021 оны А/862 дугаар захирамжийн хүрээнд:**

1. Нийслэлийн хот байгуулалтын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Сүхбаатараар Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын ажиллах 7 хоног бүрийн хуваарийг 37 удаа батлуулав.

2. Газрын дарга С.Төмөрдуламаар "Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын ажиллах 7 хоног бүрийн 39 хуваарийг тус тус батлуулан ажиллаж байна.

3. Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах хуваарь батлагдахаас өмнө Нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй баригдсан барилга байгууламжийн жагсаалтад орсон эсэхийг тодруулан хяналт тавьж ажиллав.

4. Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдварын тархалт дахин дэгдсэнтэй холбоотой хязгаархал зорилгоор Засгийн газрын 2020 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 178 дугаар, "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 181 дүгээр тогтоолын хүрээнд:

"Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал"-ын үед комиссын үйл ажиллагаанд саадгүй оролцуулах нөхцлөөр хангах зорилгоор "Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үед Барилга байгууламж, их засвар, шинэчлэлт, гадна тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах удирдамж" боловсруулан батлуулж мөрдлөг болгон ажилласан.

"Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн хүрээнд Барилга байгууламж, цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн ажил, барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажил, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах нийт **108** объектийн комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж стандарт, шаардлагад нийцүүлэн зохион байгуулж ажилласан.




Зураг 36. Барилгын хөгжлийн төвтэй зохион байгуулсан уулзалтын үйл явц

Хүснэгт 3. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт шийдвэрлэсэн байдал /2021.01.01-ээс 2021.12.15/

| № | Байгууллага, аж ахуй нэгж, иргэнээс ирүүлсэн комисс | Ирсэн хүсэлтийн тоо | Комиссын хуваарьт орж ажилласан | Комиссын дүгнэлт баталгаажсан |
|---|---|---|---|---|
| 1 | Барилга, байгууламж | 308 | 275 | 245 |
| 2 | Их, засвар шинэчлэлт, тохижилт | 325 | 309 | 145 |
| 3 | Гадна цахилгаан, гэрэлтүүлэг | 319 | 509 | 437 |
| | **Нийт** | **952** | **1093** | **827** |



Зураг 37. Комисс ажиллах явц

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгаар Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороонд 200 хүүхдийн ортой, 2 давхар цэцэрлэгийн барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулан гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах шийдвэр гаргаж комиссын дүгнэлт баталгаажих шатанд комиссын гишүүдээр хянагдаж байна.



Зураг 38. 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга

# ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

## 4.1. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэд, олон нийтийн хотын стандартын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах, газрын үйл ажиллагааг ил тод байлгах зорилгоор байгууллагын зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ өгөх 2021 оны хуваарийг Газрын даргаар батлуулав.

Хүснэгт 4. Газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажиллах хүрээнд өгсөн ярилцлага

| Д/д | Ярилцлага өгсөн албан хаагч | Сэдэв | Телевиз | Он сар өдөр |
|---|---|---|---|---|
| 1 | Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн дарга Б.Ариунтуяа | “Стандартын шаардлага хангахгүй хүүхдийн тоглоомын талбай” | Eagle | 2021.03.23 |
| 2 | Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Цогтбилэг | “Явган хүний замын стандарт” | C1 | 2021.03.10 |
| 3 | Газрын дарга С.Төмөрдулам | Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичгийн талаар | UBS | 2021.03.30 |
| 4 | Газрын орлогч дарга О.Оджаргал | Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/177 дугаар захирамжийн хэрэгжилт | ETV | 2021.04.02 |
| 5 | Газрын орлогч дарга О.Оджаргал | Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичгийн талаар | NTV | 2021.05.14 |
| 6 | Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн дарга Б.Ариунтуяа | Хүүхдийн тоглоомын талбайн стандарт | Eagle | 2021.06.02 |
| 7 | Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн дарга Б.Ариунтуяа | Хүүхдийн тоглоомын талбайн стандарт | NTV | 2021.06.03 |
| 8 | Бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Г.Амартүвшин | Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичгийн талаар | MNB | 2021.07 |
| 9 | Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Г.Бүтэнбаяр | Зуух пийшин галлагааны баримт бичиг | UBS | 2021.09.11 |
| 10 | Бодлого төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Ариунзаяа | Зуух пийшин галлагааны баримт бичиг | Өнөөдөр сонин | 2021.09.11 |
| 11 | Газрын орлогч дарга О.Оджаргал | Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичгийн талаар | ETV | 2021.10.27 |
| 12 | Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга Н.Билэгсайхан | Хашаа, хайс, Барилгын гадна орчны стандарт | Urug.mn | 2021.08.30 |
| 13 | Барилга байгууламжийн хяналтын хэлтсийн дарга Д.Жүрмэддорж | Барилга байгууламжийн стандарт /Дээвэр нэвтрүүлэг/ | Mongol HD | 2021.09 |
| 14 | Газрын орлогч дарга О.Оджаргал | Өглөөний мэнд Улаанбаатар /Явган хүний зам, Дугуйн замын стандарт/ | UBS | 2021.09 |
| 15 | Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Г.Бүтэнбаяр | Аялал жуулчлалын газрын стандарт Өглөөний мэнд Улаанбаатар | UBS | 2021.10 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **16** | Газрын дарга С.Төмөрдулам | Хот цуврал нэвтрүүлэг | Eagle | 2021.10 |
| **17** | Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Гэрэлт-Од | Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах шаардлага | NTV | 2021.11.30 |
| **18** | Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга Н.Билэгсайхан | Хүүхдийн тоглоомын талбайн стандарт | TV8 | 2021.12.07 |



Зураг 39.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгч буй байдал

### 4.1.2 Хотын стандартын удирдамж зүйн баримт бичгийг сурталчлах хүрээнд:

Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг сурталчилах, олон нийтэд мэдээллэх ажлын хүрээнд “Нийгмийн дэд бүтэц” бүлгийн 6 баримт бичиг, “Зорчигч тээврийн үйлчилгээ” бүлгийн 3 баримт бичиг, “Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө” бүлгийн 1 баримт бичиг нийт 10 баримт бичгийн танилцуулгыг байгууллагын цахим хуудаст нийтэлж ажиллалаа. Үүнээс “Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах шаардлага” баримт бичгийг Нийслэлийн мэдээ, ulaanbaatar.mn-д нийтлүүлж ажилласан.



Зураг 40.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгч буй байдал

### 4.1.3 Байгууллагын цахим хуудас болон албан веб сайтад:

Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан “Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аянд нэгдэж, сурталчилгааны мэдээллийг байгууллагын цахим хуудас болон албан веб сайтад нийтлэн олон нийтэд хүргэж ажилласан.



Зураг 41.Байгууллагын цахим хуудсанд мэдээ байршуулсан байдал

## 4.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Байгууллагын цахим хуудсанд хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой /хөдөлмөрийн дотоод дүрэм, ёс зүйн журам, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 2020 оны 103 А тушаал, сул орон тооны мэдээлэл, албан хаагчдын холбоо барих мэдээлэл/ 15 төрлийн мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас www.standard.ub.gov.mn -д байршуулсан.



Зураг 42.Байгууллагын цахим хуудсанд хүний нөөцийн мэдээлэл байршуулсан

- Цахим хуудасны шинэчлэлт, сайжруулалттай холбоотойгоор 2019, 2020 оны А тушаал, сул орон тооны захиалгын зар, бусад мэдээллийг бэлтгэн байршуулуулсан.
- Байгууллагын гадна мэдээллийн самбарт үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулан шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүрт сольж шинэчлэн байршуулсан.
- Газрын нийт албан хаагчдад тухай бүрт батлагдан гарсан тушаал, шийдвэрийг танилцуулах, цаг үеийн мэдээллийг түргэн шуурхай хүргэх, байгууллагын хэмжээнд дагаж, мөрдөх дүрэм журам, журмын шинэчлэлт, шинээр томилогдсон болон сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын

мэдээллийг танилцуулах сонсох ажиллагааг тухай бүрт зохион байгуулж ажлын фейсбүүк группд зарим холбоотой мэдээллийг оруулан, албан хаагчдыг мэдээллээ цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн.

### 4.2.2 Хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангуулах

А) Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах 2021 оны төлөвлөгөөг 2021.01.20-нд газрын даргаар батлуулсан. 2021 оны 1-2 дугаар улиралд "Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандарт"-ыг байгууллагад нэвтрүүлэх үйл ажиллагаа нь хэрэгжсэн ба Тэргүүлэх-9, Дотоод аудитор-19 албан хаагч бэлтгэгдэн мэргэшсэн. 2021 оны 3-р улиралд Газрын даргын А/26, А/32 дугаар тушаалаар төлөвлөгөөнд тусгагдсан дараах сургалтад албан хаагчдыг хамруулж ажиллалаа. хамрагдах боломж бүрдэн 9 албан хаагчдыг хамруулсан. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны А3 гэрчилгээ олгох сургалтад-6
- Хүний нөөцийн ахисан түвшний сургалтад-1,
- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад-2

Б) 2021 оны I-IV улиралд албан хаагчид нь мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, мэргэшсэн байх шаардлагыг хангаж ажиллах хүрээнд дараах төрлүүдээр мэргэшлээ дээшлүүлэн, зэрэг горилохоор суралцаж төгссөн байна. Үүнд:

- Төрийн удирдлагын магистр-6 (Э.Даваахатан, Н.Билэгсайхан, П.Отгонцэрэн, Ц.Нямцэвээн, У.Санчир, А.Энхзаяа),
- Геодезийн Зөвлөх инженер-1 (О.Рэнцэндорж),
- Геодезийн Мэргэшсэн инженер-1 (Б.Хулан),
- Усан хангамж, ариутгах татуургын Зөвлөх инженер-1 (Нямцэвээн),
- Хот байгуулалтын Мэргэшсэн архитектор-2 (Г.Бүтэнбаяр, Б.Батчимэг)

В) албан хаагчдын хууль, эрх зүй, хувь хүний хөгжил, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хүрээнд нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг сургалт, семинарт тухай бүр идэвхтэй хамруулдаг.

Хүснэгт 5. Албан хаагчдын сургалтад хамрагдсан байдал

| № | Сургалт, арга хэмжээний нэр | Албан хаагчийн тоо | Сургалтын хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Хөгжиж буй орнууд ба цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалт-1, Хөгжиж буй орнууд ба Цахим засаглал-1, Олон улсын семинар сургалт-2 | 4 | 2021.08.03-08.31 |
| 2 | Төслийн хөрөнгө оруулалтын удирдлага, Ашиглалтын хугацааны зардал сургалтад | 4 | 2021.08.10-08.30 |
| 3 | Төслийн удирдлагын үндэс сургалт | 2 | 2021.08.24,25 |
| 4 | Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагийн Ахлах мэргэжилтнүүдэд зориулсан Баг хамт олны үр дүнтэй харилцаа сургалт-2 | 2 | 2021.08.11 |
| 5 | Нийслэлийн удирдах ажилтнуудад зориулсан Манлайллын сургалт-1 | 1 | 2021.08.20 |
| 6 | Нийслэлийн эрхзүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн танилцуулга сургалт | 12 | 2021.09.15 |
| 7 | Нутгийн захиргааны байгууллагын Хүний нөөцийн ажилтнуудад зориулсан Хууль эрх зүй, систем ашиглалтын сургалтад-1 | 1 | 2021.09.20 |
| 8 | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Цогц чадамжид суурилсан Хүний нөөцийн удирдлага сэдэвт вакум сургалт | 1 | 2021.09.21,22 |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан Манлайллын сургалт | 2 | 2021.09.23,24 |
| 10 | ОУ-ын семинар- Хөгжиж буй орнуудын стандартчилал, баталгаажуулалт, магадлан итгэмжлэл ба хамтын ажиллагаа сургалт | 1 | 2021.10.23-11.03 |
| 11 | Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нь | 5 | 2021.10.06 |
| 12 | МУ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт Алсын хараа-2050 сэдэвт сургалт | 6 | 2021.10.11-10.22 |
| 13 | Орон сууцны статистик мэдээлэл, сургалтад | 8 | 2021.12.02 |
| 14 | УБ хотын түүх, ННЗБ-уудын бүтэц, зохион байгуулалт сэдэвт сургалт | 3 | 2021.10.20 |
| 15 | Хүний эрх ба ялгаварлан гадуурхалт, гэрч хохирогчийн хамгаалах үйл ажиллагаа цахим сургалт | 5 | 2021.10.22 |
| 16 | Барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь | 5 | 2021.10.27-11.30 |
| 17 | Ногоон барилгын стандарт /edge/ | 5 | 2021.12.02 |
| 18 | ТАХ-ын Ёс зүйн сургалт | 34 | 2021.11.22 |
| 19 | ТАХ-ын Манлайлал | 34 | 2021.12.06 |
| Нийт 19 төрлийн сургалтад 35 албан хаагч хамрагдаж мэргэжил, ур чадвараа дээшлүүлэн ажил, албан тушаалдаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | | | |

### 4.3. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн ажиллаж, шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд буюу сар бүрийн 08-ны өдөр шилэн дансны нэгдсэн системд мэдээллийн байршуулан ажиллаж байна. 2021 оны байдлаар нийт 109 удаа шилэн дансны мэдээллийг шинэчлэн байршуулав.

## ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

### 5.1. НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БУСАД БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

**Стандартын техникийн хорооны бүрэлдэхүүнд ажиллах тухай**

Нийслэл хотын бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, хотын стандартын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээгээр дамжуулан технологийн хөгжил, инновацыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж иргэдийн ая тухтай, ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах, уялдаа холбоог сайжруулах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зорилтод сургалтыг үе шаттай зохион байгуулж чанар, стандартын мэдлэг, ойлголт, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Шадар сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2021 онд хамтран ажиллах ШС-21/022 гэрээний 3.23-д тусгасан “Монгол Улсын үндэсний стандартчиллын техникийн хороо, дэд хороодод нийслэлийн төлөөллийг оролцуулах” заалтын хүрээнд үндэсний болон олон улс, бүс нутгийн стандартын төслийг хэлэлцэх, стандарт боловсруулалтын түвшин, агуулга зохих шаардлагад нийцсэн эсэхийг хянах, үндэсний болон олон улс, бүс нутгийн стандартын төсөлд санал өгөх, дүгнэлт гаргах зэрэг үйл ажиллагаанд оролцох зорилгоор “Тогтвортой хот” ТХ 50 дугаартай техникийн хорооны

бүрэлдэхүүнд гишүүн болон ажиллах хүсэлтэй байгаа тухай 01-04/180 дугаар албан бичгийг Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлэв.

**Хот байгуулалт, барилгажилт, түүний үйл ажиллагаанд стандартын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах:**

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зөвшөөрөлгүй барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй нийт 116 барилгын жагсаалтын судалгааг гаргаж 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр тус газрын 2 албан хаагч Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд байршил дээр нь баталгаажуулан мэдээг бэлтгэн удирдлагад танилцуулав.





Зураг 43. Байршилд ажилласан явц

**Стандарт, норм дүрмийг боловсруулах, өөрчлөх, шинэчлэх талаар гадаад, дотоодын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, санал солилцох ажлын хүрээнд:**

Нийт 29 стандарт, 19 барилгын норм ба дүрмийг судлан тухай бүр хугацаанд нь саналыг хүргүүлж ажиллав.

## 5.2. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 5.2.1. Удирдлагын зөвлөлийн хурал

Газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хурал болон нийт албан хаагчийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Удирдлагын зөвлөлийн хурлыг 2021 онд 7 удаа зохион байгуулж нийт 26 асуудлыг хэлэлцэж хэлтэс, албан хаагчдад холбогдох үүрэг чиглэлийг өгч биелэлт хангуулах хяналт тавьж ажилласан байна. Тус хурлаас нийт 39 үүрэг даалгавар өгөгдсөнөөс 90 хувийн хэрэгжилттэй.

Орлогч даргын даргалан явуулсан нийт албан хаагчидтай хийсэн 3 удаагийн хурлын тэмдэглэл хөтлөн баталгаажуулж, хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр гарган ажиллав.

### 5.2.2. Ажлын төлөвлөгөө, тайлан боловсруулах

**Байгууллагын цаг үеийн ажлын төлөвлөгөөний биелэлт**

2021 оны газрын цаг үеийн ажлын төлөвлөгөөг нийт 10 удаа боловсруулан батлуулж төлөвлөгөөний биелэлтийг холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн биелэлтийг газрын удирдлагад танилцуулан ажиллав. Үүнд:

Хүснэгт 6. Цаг үеийн ажлын төлөвлөгөөний биелэлт

| № | Хамрах хугацаа | Төлөвлөсөн ажлын тоо | Биелэлтийн дундаж хувь |
|---|---|---|---|
| 1 | 2021.03.01-2021.03.12 | 17 | 63% |
| 2 | 2021.03.15-2021.03.30 | 29 | 82% |
| 3 | 2021.04.10-2021.04.25 | 14 | 76% |
| 4 | 2021.05.03-2021.05.14 | 20 | 96% |
| 5 | 2021.05.17-2021.05.31 | 37 | 66% |
| 6 | 2021.06.01-2021.06.15 | 32 | 60% |
| 7 | 2021.07.01-2021.07.30 | 36 | 75% |
| 8 | 2021.08.02-2021.08.13 | 39 | 69% |
| 9 | 2021.08.16-2021.08.31 | 36 | 74% |
| 10 | 2021.11.01-2021.11.15 | 25 | 82% |
| **НИЙТ** | | **285 /давхардсан тоогоор/** | **80 хувь** |

## 5.3. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2021 оны байдлаар хүний нөөцийн бодлого, хэрэгжилттэй холбоотой 47 “Б” тушаал, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 42 “А” тушаалыг тус тус боловсруулсан. А,Б тушаалын төслийг хэвлэмэл хуудсанд буулгаж тэмдэг дарж, дугаар олгон газрын даргын нийт 89 шийдвэрийг албажуулав.

**Албан тушаалын тодорхойлолт батлуулах хүрээнд:**

Тус газрын албан тушаалын тодорхойлолт 2020 оны 4 дүгээр сард батлагдсаны дараа тухайн оны 7 дугаар сард Нийслэлийн Засаг даргын А/1000, А/1011 дүгээр захирамжаар байгууллагын дүрэмд нэмэлт өөрчлөлт орж чиг үүргийн дагуу шилжиж ирсэн “Барилга байгууламжийн хяналтын хэлтэс”-ийн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны тухай хууль, түүнтэй уялдан гарсан холбогдох дүрэм, журам, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэгт нийцүүлэн төрийн захиргааны 11 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн албан тушаалын тодорхойлолт баталгаажуулах комиссын хурлаар оруулан урьдчилсан харьцуулалт батлагдсан. Дээрх 11 тодорхойлолтыг баталгаажуулан тогтоол болгон гарах явцад Төрийн албаны төв зөвлөл нь дахин нягтлан шалгаж, чиг үүргийн шинжилгээ хийх шаардлагатай гэж үзэн нийслэл дэх салбар зөвлөлд уг ажлыг хийж гүйцэтгэн ирүүлэхийг даалгасан. Салбар зөвлөл нь одоог хүртэл ажлын байрны шинжилгээ хийж, дүгнэлтийг хүргүүлээгүй байна. Энэ хугацаанд нийт 5 удаа НЗДТГ-ын Хүний нөөцийн удирдлагын тасгаас тодруулж асуухад тодорхой хариу өгөлгүй, хариуцсан гүйцэтгэж байгаа хүн байхгүй байна.

**Төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах хүрээнд:**

Тусгай шалгалт 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулагдаж албан хаагчид тусгай шалгалтад амжилттай оролцсон. 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 14/20 дугаар албан бичгээр тусгай шалгалтад тэнцсэн албан хаагчдыг нэр дэвшүүлэн томилох тухай Нийслэл дэх салбар зөвлөлийн 6 тогтоолыг хүлээн авч газрын даргын Б/09, 10, 11, 12, 13, 17 дугаар тушаалаар баталгаажуулан, тогтоолын хэрэгжилтийн ханган ажилласан тухай шийдвэрийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01-03/66 дугаар албан бичгээр хүргүүлэн ажилласан.

41. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
42. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Хүрээлэн буй орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
43. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Захиргааны хэлтсийн Дотоод ажил, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
44. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Мэдээлэл, технологийн хэлтсийн Мэдээллийн сангийн мэргэжилтэн
45. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хот төлөвлөлтийн стандартын мэргэжилтэн
46. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн Орчны стандарт нэвтрүүлэлтийн мэргэжилтэн

Зураг 44. Сонгон шалгаруулалтын зар байршсан байдал

Гүйцэтгэх албан тушаалын 5 сул орон тоог нөхөн бүрдүүлэх захиалгыг боловсруулж Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлд 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 01/03-144 дүгээр албан бичгээр захиалгыг хүргүүлсэн. (Бодлого төлөвлөлтийн хэлтэст-2, Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтэст-1, Орчны аюулгүй байдлын хэлтэст-1, Мэдээлэл, технологийн хэлтэст-1, нийт 1 ахлах мэргэжилтэн, 4 мэргэжилтэн). Төрийн албаны төв зөвлөл нь цар тахалын нөхцөл байдал болон МУ-ын 8 дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагаа дууссан дараа сонгон шалгаруулалтыг зохион байгуулж эхлэхээр төлөвлөсөн талаар салбар зөвлөлөөр дамжуулан мэдэгдсэн. Иймд дээрх тусгай шалгалт нь 2021 оны 7 дугаар сард зохион байгуулагдах төлөвтэй байна.

**<u>Мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг хамруулсан байдал:</u>**

2021 оны 1-р улирлын байдлаар Нийслэлийн Засаг даргын тамгын газраас "Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх 40 цагийн богино хугацааны зайн сургалт"-д хамрагдах албан хаагчдын санал авсны дагуу тус газраас шаардлага хангасан 4 албан хаагч (Б.Хулан, Г.Амартүвшин, М.Цогтбилэг, Б.Ариунзаяа)-ийг уг сургалтад бүртгүүлсэн. Багц сургалтын хөтөлбөрийг 2021 оны 3 дугаар сарын 15-наас 28-ны өдрүүдэд цахимаар судалж төгссөн ба Нийслэлийн Засаг даргын тамгын газраас дээрх албан хаагчдын үнэмлэхийг 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдөр хүлээн авсан. (Үнэмлэхний дугаар: №21/2163, 21/2164, 21/2165, 21/2166) Сургалтын талаарх мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн нэгдсэн системд бүртгэн баяжуулж, албан хаагчдын хувийн хэрэгт үнэмлэхний хуулбарыг хийж тус тус баяжуулсан.

Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалт, Богино дунд хугацааны сургалт 2 дугаар улирлын байдлаар хараахан зохион байгуулагдаагүй байна.

**<u>Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой судалгаа, мэдээллийг нэгтгэх, гаргах, хүргүүлэн ажиллах хүрээнд:</u>**

Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын тасаг, Байгууллагын хүний нөөцийн 2021 оны үйл ажиллагаатай уялдуулан цаг тухай бүрт нь боловсруулж, шинэчлэн гаргасан дараах судалгаа, мэдээллийг нэгтгэж боловсруулж ажилласан. Үүнд:

- Албан хаагчдын улсад, төрийн байгуулагад ажилласан жилийн судалгааг шинэчилсэн;
- Албан хаагчдын зэрэг дэвийн судалгаа;
- Төрийн албанд анх томилогдсон иргэнийг төрийн албаны онцлог, стандарт, шаардлагад нийцэн ажиллах мэдлэг ур чадвар эзэмшүүлэх 40 цагийн чиглүүлэх сургалтад хамрагдах шаардлагатай албан хаагчдын судалгаа;
- Цар тахлын халдварыг бууруулах, үүссэн голомтуудыг хяналтанд авах зорилгоор Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу Коронавирусийн голомтын бүсэд хязгаарлалтын дэглэм болон хэв журмыг

сахиулан дайчлагдан ажиллах ажилтан, албан хаагчдын судалгаа (овог нэр, регистрийн дугаар, гэрийн хаяг, холбогдох утасны дугаар, авто машины дугаар);

- Байгууллагын эрэгтэй албан хаагчдын судалгаа;
- Орон сууцны нөхцөлийн судалгаа;
- Боловсролын түвшины судалгаа;
- Албан хаагчдын мэргэшүүлэх сургалт, бусад төрлийн сургалтуудад хамрагдсан судалгаа.

**Цаг бүртгэлийн тооцоо гаргах, цагийн бүртгэлтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд:**

Газрын нийт албан хаагчдын цаг бүртгэлийн төлвийг бүртгэж өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай, эрх нээх зэрэг асуудлыг тухай бүрт шийдвэрлэн ажиллаж албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийн тооцоог нэгтгэн Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтад заасан маягтын дагуу сард 2 удаа гаргаж Ахлах нягтлан бодогчид баталгаажуулан өгч албан хаагчдын цалинг цаг хугацаанд олгуулан ажилласан. 2021 онд Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх хүрээнд зарим албан хаагчид зайнаас ажиллах үед Google sheet ажлын цахим хуудсанд ажлаа тайлагнасан зэргийг харгалзан ажлын цаг ашиглалт, өдөр бүрийн цаг бүртгэлд тогтмол хяналт тавин ажиллав.

Erp системээр ирүүлсэн 55 хүсэлтийг хүлээн авч учир шалтгаан, мэдэгдэлтэй танилцаж хавсарган ирүүлсэн материал, эмнэлэгийн хуудас, үндэслэл зэргийг харгалзан удирдлага, хамаарах хэлтсийн дарга нараас тухай бүр тодруулан бүрэн тайлбар бичиж дээрх 55 хүсэлтийг шийдвэрлэн цаг бүртгэлийн төлөвийг сайжруулан ажилласан.



*Зураг 45. Цаг бүртгэлийн төлөв хөтлөлт 3-р сарын байдлаар*

**Албан хаагчдыг мэдээллээр хангах, Ажлын үнэмлэх олгож ажиллах хүрээнд:**

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэл, холбогдох тогтоол, захирамж, тушаал шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн журам зэрэг 80 хуудас бүхий зайлшгүй уншиж судлах материалыг хэвлэн товъёоглож албан хаагчдаар уншуулан гарын үсэг зуруулж баталгаажуулж ажилласан. Газрын нийт албан хаагчдын үнэмлэхний загварыг шинэчлэн QR кодтой болгож нийт 42 албан хаагчдад ажлын үнэмлэх олгосон.

**Хүний нөөцийн бодлого хэрэгжилт, үр дүн:**

бүртгэлийг дээрх хоёр систем тус бүрт нь бүртгэж баяжуулсан ба 2021 оны байдлаар 54 төрлийн дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэж шинэчилж системийг хөгжүүлсэн байна.

Энэхүү хоёр системээс төрийн албан хаагчидтай холбоотой мэдээлэл, судалгааг гарган авч Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөл, Нийслэл дэх салбар зөвлөлийг шуурхай мэдээллээр хангаж, өдөр тутмын үйл ажиллагааг цахимжуулан ажиллав.

**Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийн биелэлт:**

2020 оны хөтлөгдсөн хөдөлмөрийн гэрээг баталгаажуулан архивт хүлээлгэн өгсөн. 2021 оны 1-4 дүгээр улиралд 8 ажилтан, албан хаагчтай хөлмөрийн гэрээ байгуулсан. Гэрээ тус бүрт гүйцэтгэн ажиллах албан тушаалын тодорхойлолтын үндсэн агуулгыг тусган өгч, гэрээний хугацааг анхааруулан батлагдсан албан тушаалын тодорхойлолтын хамт хүлээлгэн өгөв.

**Албан хаагчдын 2021 оны ээлжийн амралтын хүрээнд:**

2021 оны албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийн саналыг хэлтэс тус бүрээс авч нэгтгэн газрын даргад танилцуулан 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/06 дугаар тушаалаар батлуулав. 14 албан хаагчдийн мэдэгдэх хуудсыг боловсруулан, орлон ажиллах хуваарийн дагуу ажил хүлээлцүүлэв.

Газрын удирдлагуудын 2021 оны ээлжийн амралтын саналыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтэст 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлсэн.

## 5.4. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ТАЙЛАН МЭДЭЭ

5.4.1. 2021 оны байдлаар байгууллагын хэмжээнд хяналтад авагдсан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолоор 10, 2021 оны 45 дугаар тогтоолоор 1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 119 дүгээр тогтоолоор 1 үүрэг даалгавар өгөгдсөн нийт 12 заалтын хүрээнд дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүн, мэдээнд хяналт шинжилгээ хийж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээг хагас бүтэн жилээр нэгтгэн гаргаж Газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст албан бичгээр хүргүүлэв.

5.4.2.Байгууллагын хэмжээнд ирсэн Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шинжилгээ хийж хэрхэн шийдвэрлэсэн байдал болон шийдвэрлэлтэд анхаарах асуудлаар газрын удирдлагын Зөвлөлийн хуралд танилцуулга бэлтгэн нийт албан хаагчдад үүрэг чиглэл хүргүүлсэн.

5.4.3.Газрын даргын 2021 оны “Албан хаагчдын сахилга, дэг журам, ёс зүйн шаардлагыг хангуулах арга хэмжээний тухай” А/11 дүгээр тушаалаар Албан хаагчдад сахилга, хариуцлага, ёс зүйн шаардлагыг мөрдүүлэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн албаны тухай хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн нийтлэг үүргээ хангалтгүй биелүүлсэн, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн албан хаагчдыг бүртгэх, баримтжуулах зориулалт бүхий хяналтын шар, улаан хуудасны загварыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.



Зөвхөн дотоод хэрэгцээнд

ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ХЯНАЛТЫН ШАР ХУУДАС

№ .....

Ажлын цаг ашиглалт

БАТАЛГААЖУУЛАЛТ



Зөвхөн дотоод хэрэгцээнд

ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ХЯНАЛТЫН УЛААН ХУУДАС

№ .....

БАТАЛГААЖУУЛАЛТ

Зураг 48. Хяналтын шар, улаан хуудас

2021 онд газрын хэмжээнд улаан хуудас 1 албан хаагч, шар хуудас 21 албан хаагч нийт 22 албан хаагчдад эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр олгож байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулан ажиллав.

5.4.4.Газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.1.10-т “Албан хаагчид өдөр бүрийн ажлын товч тэмдэглэлийг нийт албан хаагчдын дундын цахим файлд тухайн өдөртөө багтаан тэмдэглэж удирдлагыг цаг үеийн мэдээллээр хангаж ажиллах бөгөөд албан хаагчдын ирцийг цаг бүртгэлийн системээс гадна дээрх ажлын өдөр тутмын тэмдэглэлээр баталгаажуулна” гэсэн нэмэлт өөрчлөлтийг оруулан батлуулан албан хаагчдын дундын цахим файл “Google sheet”-д өдөр бүр тогтмол хяналт тавьж ажиллав.

5.4.5.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу газрын даргын 2021 оны А/10 дугаар тушаалаар байгуулагдсан байгууллагын “Үнэлгээний баг”-ийн бүрэлдэхүүн нийт албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланд 1,3 дугаар улирадл явцын ярилцлага зохион байгуулан 2021 оны хагас бүтэн жилээр нийт албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэн газрын “Удирдлагын зөвлөл”-ийн хуралд танилцуулан холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангуулан ажиллав.

5.4.6.Нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан” Imonitoring.ulaanbaatar.mn-д Нийслэлийн Засаг даргын захирамж-15, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл-8 нийт 23 дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн гаргаж тухай бүр тайлагнан ажиллав.




График 6. Imonitoring.ulaanbaatar.mn-д тайлагнасан байдал.

## 5.5. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2021 онд байгууллагын хэмжээнд нийт ирсэн, явсан бичиг иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг харуулав.




- **1506** албан бичгийн **1479**-ыг хугацаанд нь шийдвэрлэсэн, **27** албан бичгийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн.
- Өргөдөл нийт **209** ирснээс хугацаанд нь **205**-ийг хугацаанд нь, **4** хүсэлтийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна.

Хугацаанд нь шилжүүлээгүй **3,** Явц бичээгүй **37**, өдөрт нь аваагүй **44** **нийт 84** зөрчил үүссэн байна.

График 7.Албан бичиг шийдвэрлэлт

**Иргэдийн өргөдөл,гомдлын талаар нийт 209 иргэн хандсан байна. Үүнд:**

| Ангилал | Нийт | Шийдвэрлэсэн |
|---|---|---|
| Хүсэлт | 134 | 134 |
| Гомдол | 67 | 67 |
| Санал | 5 | 5 |
| Мэдэгдэл | 3 | 3 |
| **НИЙТ** | **209** | **209** |

Хүснэгт 7. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт

Байгууллагад 2021 онд боловсруулагдаж архивт нөхөн бүрдүүлэлтээр өгөх баримтын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах ажлын хүрээнд:

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад захиргааны хэлтэс 66 нэр төрөл, бусад хэлтсүүдээс авсан саналын дагуу боловсруулан нийт 112 төрлийн баримтаас байнга хадгалах 46, түр хадгалах 62, 70 жил хадгалах 4 баримтын жагсаалтын хадгалах хугацааг үнэн зөв боловсруулан Нийслэлийн Архивын газарт 2021 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хянуулахаар ERP системээр хүргүүлсэн.

### Архивын ажлын хүрээнд:

Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн удирдлагын нийтлэг баримт бичиг хадгалах, хөмрөг үүсгэх, хадгаламжийн нэгж бүрдүүлэх, хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын дагуу бүрдүүлсэн баримт бичгийг, нягтлан шалгаж, эмхлэн цэгцлэх, сэлбэн засах сэргээн шинэтгэх ажлууд хийгдсэн. Архивын нөхөн бүрдүүлэлтээр 2020 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын батлагдсан хуваарийн дагуу 2021 оны 1-р улиралд багтаан 217 архивын баримт хадгаламжийн нэгж хүлээн авав.

Байгууллагын архивын санд 2019, 2020 оны нийт цаасан суурьтай 333 боть хадгаламжийн нэгж Үүнд:

- Байгууллагын байнга хадгалагдах -6
- Байнга хадгалагдах -136
- 70 жил хадгалагдах -7
- Түр хадгалагдах -184

цахим санд 30 хадгаламжийн нэгж бүхий 60 ш CD ,DVD

- Захирамжлалын цахим баримт -2
- Тендерийн цахим баримт -22
- Байгууллагын байнга хадгалагдах цахим баримт -6 хадгаламжийн нэгжид данс

бүртгэл үйлдэж, хөмрөг данс, хадгаламжийн нэгжийн дугаартай болсон. 2020 оны захирамжлалын цахим баримт газрын даргын А,Б тушаалуудын мастер хувийг DVD хуулан, Нийслэлийн Архивын газрын Төрийн Архивын хэлтэст хүлээлгэн өгсөн.




*Зураг 49. Хадгаламжийн нэгжийн хөмрөг үйлдсэн байдал*




График 8. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгасан баримтууд, тоогоор

Байгууллагад хөтлөгдөх баримтын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын саналыг хэлтсүүдээс авч нэгтгэн шинэчлэн боловсруулж нийслэлийн Архивын газрын ББНШК-н хурлаар 2021 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр хурлаар танилцуулан зөвшөөрөгдөж, 2021 оны 11 дугаар сарын 08-ний өдөр баталгаажуулж 1 эх хувиар хүлээн авч мөрдөн ажиллаж байна. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад 52 хэрэг тусгагдсан . Үүнд:

- Байнга хадгалах - 25
- Түр хадгалах -23
- 70 жил хадгалах -4 хэрэг байна.

| Д/д | Хэлтэс | Он сар өдөр |
|---|---|---|
| 1 | Мэдээлэл технологийн хэлтэс | 2022.01.25-28 |
| 2 | Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтэс | 2022.01.10-15 |
| 3 | Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс | 2022.01.17-21 |
| 4 | Бодлого төлөвлөлтийн хэлтэс | 2022.01.12-18 |
| 5 | Барилга байгууламжийн хяналтын хэлтэс | 2022.01.24-28 |
| 6 | Захиргааны хэлтэс, санхүү, нярав | 2022.01.06-25 |

*Хүснэгт 8. Архивын баримт хүлээлгэн өгөх хуваарь*

## 5.6. БУСАД НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙ АЖИЛ

### Өмч хамгаалах комиссын үйл ажиллагаа

2021 оны байдлаар хагас жил, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг Газрын даргын А/22, А44 дүгээр тушаалаар 2 удаа байгуулсан.

Байгууллагын 2021 оны үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр зохион байгуулан газрын дарга болон мэргэжилтнүүд нийт 40 албан хаагчдын эд хөрөнгөнд бүртгэл тооллого хийж нийт албан хаагчдын эд хариуцагчийн картыг хянаж шинээр ажилд орсон албан хаагчдад эд хариуцагчийн карт шинээр нээж ашиглаж буй эд хөрөнгийг данс бүртгэлээр шилжүүлэн хүлээлгэн өгч хариуцуулан ажиллав.

**Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой хууль,тогтоомжид санал өгсөн байдал**

Нийслэлд хотын стандартын тогтолцоог бүрдүүлэх бэлтгэл хангах зорилгоор Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, түүний итгэмжлэлийн тухай хуулийн төслүүдэд "Хотын стандарт"-ын үндэс суурийг тодорхойлох, мөрдүүлэх талаар холбогдох зүйл заалтыг тусган оруулахаар санал өгсөн. Түүнээс гадна нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хууль, тогтоомжийн төслүүдэд чиг үүргийн хүрээнд санал өгч хамтран ажилласан.

Газрын чиг үүрэгтэй холбогдох чиглэлээр хуулийн төсөлд өгсөн саналууд:

| № | Баримт бичгийн төрөл | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| 1 | Хуулийн төсөл | 4 | 3 | 11 |
| 2 | Журмын төсөл (МУЗГ, НИТХ-ын тогтоолын төсөл) | 3 | 3 | 3 |
| | **Нийт** | **16** | **20** | **6** |

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажил**

<u>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</u>

Албан хаагчдыг цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор нэг удаагийн амны хаалт, бээлий, гар ариутгах бодис, нүүрний хаалт зэргийг нийлүүлж зайлшгүй шалтгаанаар цар тахлын оргил дэгдэлтийн үед ажиллаж байгаа албан хаагчдыг хамгаалах хэрэгслээр хангав.




Зураг 50. Халдвар хамгаалын хэрэгсэл худалдан авсан байдал

Ковид-19 цар тахлын хүрээнд танхимаар ажиллах албан хаагчдад халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн мөрдөх, ажлын байран дээр ариутгал цэвэрлэгээ хийх зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлтэй хамтран боловсруулсан. Мөн дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжид тусгасан цар тахлын үед ажлын байран дээр анхаарах дэглэмийг 01 дүгээр сарын 13-ны өдөр газрын нэгдсэн хуралдаанаар албан хаагчдад танилцууллаа.




Зураг 51. Танилцуулга, мэдээлэл хийсэн байдал

## Эрүүл мэндийн үзлэг

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулах арга хэмжээ байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан.

Уг арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 340 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14.1, 26.5.2 дахь хуулийн заалтыг үндэслэн байгууллагын албан хаагчдыг 2021 онд хугацаат үзлэгт хамруулах саналыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн гишүүдээс хамтран боловсруулж батлуулсан.

Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгийг 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр “Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгт” -тэй хамтран зохион байгуулав.





Зураг 52. Албан хаагчид үзлэгт хамрагдаж байгаа байдал

Улаанбаатар хотод газар хөдлөлтийн  газар хөдлөлтийн чичирхийлэл мэдрэгдэж байгаа тул албан хаагчдыг сургаж дадлагажуулах, аюулгүй байдлыг хангах бэлтгэлийн хүрээнд танилцуулга бэлтгэх, мэргэжлийн байгууллагаас сургалт авах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.




Зураг 52.Сургалтын материал

Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй тохижилт бүтээн байгуулалтын ажилд зөвлөн туслах зорилгоор ажиллах албан хаагчдад ХАБЭА-н анхаарах зүйлс сэдэвт сургалтыг 07 дугаар сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулав.






"ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА" ЗӨВЛӨН ТУСЛАХ ЗОРИЛГООР ТАЛБАЙД АЖИЛЛАХДАА АНХААРАХ АСУУДЛУУД" СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДСАН АЛБАН ХААГЧДЫН БҮРТГЭЛ

2021 оны 07 дугаар сарын 20-ний өдөр — Улаанбаатар хот

| № | Овог, нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|

Зураг 53. Сургалтын бүртгэл материал

**Залуучуудын зөвлөлийн ажил**

**Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:**
Тус тогтоолын хүрээнд Газрын даргын 2021 оны А/18 дугаар тушаалаар Байгууллагын дэргэдэх "Залуучуудын зөвлөл"-ийг 9 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулав. Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс зохион байгуулагдсан www.ydc.mn цахим хуудасны ашиглалт, байгууллагын зөвлөлийн гишүүдийг цахим хуудсанд бүртгэх сургалтанд хамрагдаж газрын залуучуудын зөвлөл үүсгэн, гишүүдийн бүртгэлийг хийж ажиллав.

**Бусад цаг үеийн ажил**

- **Энхтайваны гүүрний урсгал засварын ажлын харагдах байдлын зургийн боловсруулалтын ажил:**

Энхтайваны гүүрний урсгал засварын ажлын харагдах байдлын зургийг боловсруулж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д. Сумъяабазар болон хотын ерөнхий менежер Т.Гантөмөрт танилцуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллав.



Зураг 54. Энхтайвны гүүрний урсгал засварынажлын харагдах байдал

- **Чингэлтэй дүүрэг TEDY худалдааны төвийн урд тал болон Геоэкологийн хүрээлэнгийн баруун талын байршилд авто зогсоолын төлөвлөлт хийв.**

Нийслэлийн засаг даргын шуурхайгаар өгсөн үүрэг даалгаврын дагуу Нийтийн эдэлбэр газрыг хааж зөвшөөрөлгүй барьсан төмөр хашааг буулган авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Чингэлтэй дүүрэг TEDY худалдааны төвийн урд тал болон Геоэкологийн хүрээлэнгийн баруун талын байршилд авто зогсоолын төлөвлөлт хийв.




Зураг 55. Авто зогсоол төлөвлөлт

- **Чингэлтэй дүүрэг Аэрогеодизийн хажууд авто зогсоолын төлөвлөлтөд санал төлөвлөлтийг боловсруулав.**

Нийслэлийн засаг даргын шуурхайгаар өгсөн үүрэг даалгаврын дагуу Нийтийн эдэлбэр газрыг хааж зөвшөөрөлгүй барьсан төмөр хашаануудыг буулган авто зогсоолыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Чингэлтэй дүүрэг Аэрогеодизийн хажууд авто зогсоолын төлөвлөлтөд санал төлөвлөлтийг боловсруулав.




Зураг 56. Авто зогсоолын төлөвлөлт

**Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн:**

Чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг боловсруулж ажлын байрны болон удирдлага, зохион байгуулалтын сэтгэл ханамжийн судалгааг байгууллагын нийт албан хаагчдаас 10 асуулт /ерөнхий 2, үндсэн 8 асуулт/ бүхий судалгааны анкет /Google form/ ашиглан судалгааг авсан. Тус судалгаанд нийт 42 албан хаагчдаас 33 албан хаагч буюу 78% нь хамрагдсан бөгөөд судалгааны дүнг боловсруулан тайланг боловсруулж байгууллагын удирдлагуудад танилцуулав.




График 9.Судалгааны дүгнэлт

## 5.7. НИЙТ АЛБАН ХААГЧДЫН ОРОЛЦСОН АЖЛУУД:

2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Хүүхдийн ордонд Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар, нийслэлийн зарим агентлагуудын албан хаагчидтай хийсэн уулзалтад хэлтсийн нийт албан хаагчид оролцож нийслэлийн хэмжээнд тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, мэдээллийг хүргүүлэв.



Зураг 57.Уулзалтад байгууллагын удирдалгуудын зүгээс өөрсдийн байгууллагын талаар танилцуулав.

2021 онд Нийслэлийн Засаг даргын баталсан “Сая уушги-Сая мод” уриалгын хүрээнд “Өрх бүр хашаандаа мод тарья” уриатайгаар “Мод тарих зөвлөмж” боловсруулсан.



Зураг 58.Мод тарих зөвлөмж

Богд Хан ууланд 2021 оны 05 дугаар сарын 26-ны өдөр 2 га газрыг ойжуулах зорилготой “Хандлагаа өөрчилье” аянд нэгдэн мод тарьсан.




Зураг 59. Мод тарих үйл явц

**“Өнтэй өвөлжье” арга хэмжээнд оролцов.**

Нийслэлийн Засаг даргын Агаар орчны асуудал хариуцсан төслүүдийн удирдагчийн баталсан удирдамжийн дагуу "Өнтэй өвөлжье" өдөрлөг 2021 оны 09 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан. Энэ нь нийслэлийн иргэдийг 2021-2022 оны өвөлжилтийн бэлэн байдлыг хангуулах, мэдээллээр хангах зорилготой бөгөөд тус газрын зүгээс "UCS 1511C:2020 Зуух пийшин, яндангийн бүрэн бүтэн байдал, галлагаанд тавигдах шаардлага", "UCS 1505C Дулаан, дуу чимээ тусгаарлах материал", "UCS1504C:2020Хаалга цонх", "UCS1507C:2020 Халаалт, агаар сэлгэлтийн материалд тавигдах ерөнхий шаардлага" хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичгийн танилцуулгыг хийж, иргэдэд өвөлжилтийн бэлтгэл хангах, угаарын хийнээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдээллийг өгч ажиллав.







Зураг 60. *Өнтэй өвөлжье арга хэмжээний үеэр*

**Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцов.**

Нийслэлийн харьяа байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-2021 арга хэмжээнд байгууллагын хэмжээнд идэвхитэй оролцож үйл ажиллагаагаа иргэд олон нийтэд танилцуулж дараах үндсэн асуудлыг танилцуулав.

- Байгууллагын үндсэн чиг үүрэг
- Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичиг
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа
- Сайжруулсан түлшний зөв зохистой хэрэглээ
-






**Мэтгэлцээний тэмцээн:**

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Оюунчимэгийн баталсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэтгэлцээний анхдугаар тэмцээний удирдамжийн дагуу тус тэмцээнд Захиргааны хэлтсийн дарга Э.Даваахатан, Бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Г.Амартүвшин нарын хамт тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Өлзийсайхан амжилттай оролцов.

**Дэлхийн стандартын өдөр:**

Дэлхийн стандартын өдөрт зориулсан арга хэмжээг зохион байгуулж дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Албан хаагчдын танин мэдэхүй болон стандартын ойлголт мэдлэгийг баталгаажуулах, нэмэгдүүлэх зорилгоор хөгжөөнт асуулт хариултын АХА тэмцээн зохион байгуулав.
2. Үйл ажиллагаанд зориулсан торт болон хананы плакат, нэгдсэн арга хэмжээ, хөгжөөнт тоглоом зэргийг зохион байгуулав.



Зураг 61. Арга хэмжээний үйл *явц*

**Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын наадам**

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын наадамд эрэгтэй, эмэгтэй сагсан бөмбөг, ажлын байрны дасгал хөдөлгөөн гэсэн төрлөөр 2021 оны 12 дугаар сарын 14-өөс 18-ны хооронд амжилттай оролцов.




Зураг 62.Спортын наадамд оролцсон байдал

## ДҮГНЭЛТ

Тус газар нь цар тахлын эрсдэлтэй нөхцөл байдал, зайнаас ажиллах түр журмын хүрээнд дүрмээр хүлээсэн чиг үүргээ хэвийн гүйцэтгэх талаар багагүй хүчин чармайлт гарган ажиллаж байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 96 хувийн биелэлттэй гарсан.

Нийслэл хотыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт бусад нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан зарим арга хэмжээг 2022 онд эрчимжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хотын стандартын баримт бичиг боловсруулах, орчны аюулгүй байдлын судалгаа явуулах, эрсдэл зөрчлийг бууруулах, нийслэлийн хэмжээнд шинээр барьж байгуулсан барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад оруулах ажлыг нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу хэвийн гүйцэтгэж цаг үеийн ажлын талаар Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд 4 удаа танилцуулж хотын стандартын тогтолцоог бүрдүүлэх хууль эрх зүйн үндэс суурийг амжилттай тавьж нийт 22 бүлгийн 97 төрлийн хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг амжилттай боловсруулж дуусгав.

Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээг амжилттай зохион байгуулж баталгаажуулалтын гэрчилгээг хүлээн авсан нь байгууллагын дотоод засаглалыг үйл явцыг оновчтой, үр ашигтай хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн ач холбогдолтой юм.

Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэхийн тулд байгууллагын бүтэц, үйл ажиллагааг илүү оновчтой шинэчлэх, стратеги төлөвлөгөөгөө шинэчлэн батлагдах дүрмийн хүрээнд боловсруулах, хотын стандартыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах зэрэг цаг үеийн ажлууд манай хамт олныг хүлээж байна.

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА С.ТӨМӨРДУЛАМ

ТАНИЛЦСАН:
ОРЛОГЧ ДАРГА О.ОДЖАРГАЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Э.ДАВААХАТАН

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН С.БОЛДОО